



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2017 • VIII • № 10

**П.ЭРДЭНЭТУЯА:
МОНГОЛБАНКНААС
"МОНГОЛ АЛТ" АЯНЫГ
ЭХЛҮҮЛЭЭД БАЙНА**

**ЦИРКУЛЯР ЭДИЙН
ЗАСАГ /CIRCULAR
ECONOMY/,
ТҮҮНИЙГ МОНГОЛД
НУТАГШУУЛАХ
АСУУДЛУУД**



"Монгол Улсын Эрдэнэсийн сан" номноос.



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



МОНГОЛБАНКНЫ ХАНГАЙН БҮСИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголбанк 2017 онд “Орон нутаг дахь хэлтэс, салбарыг бэхжүүлэх, боловсон хүчнийг чадавхижуулах” зорилгоор бүсийн зөвлөгөөнүүдийг зохион байгуулж байна. Өнгөрсөн 7-р сард Монголбанкны Баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан.

Энэ удаад Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд 2017.08.10-14-ний өдрүүдэд Монголбанкны Хангайн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнийг нээж Монголбанкны Дэд Ерөнхийлөгч үг хэлж, Мөнгөн Тэмдэгтийн Газар, Хяналт Шалгалтын Газар, ОНБМТ, Тамгын Газрын төлөөллүүд “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тухай”, “Эдийн засгийн одоогийн нөхцөл байдал”, “Банкны нэгжийн мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагыг шалгах нь”, “Монголбанкны үйл ажиллагаанд хамаарах

нууцлалууд, аюулгүй байдал”, “Монгол алт” аяны танилцуулга зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулав.

Түүнчлэн Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Хөвсгөл, Архангай аймаг дахь Монголбанкны салбар, хэлтсүүдийн захирлууд салбарынхаа үйл ажиллагааны талаарх танилцуулга хийж, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Өвөрхангай аймгийн Засаг дарга Г.Ганболдтой уулзалт хийж санал бодлоо солилцов. Орон нутгийн Монголбанкны Хангайн бүсийн зөвлөгөөнд оролцогчид цаашид жил бүр бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах нь зүйтэй гэж дүгнэсэн юм.

Ирэх 9-р сард Монголбанкны Зүүн болон Говийн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажил, хөтөлбөрөө боловсруулаад байна.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

8-р сарын онцлох үйл явдлууд

ХУУДАС

4

Ярилцлага:

П.Эрдэнэтуяа: Монголбанкнаас
“Монгол алт” аяныг эхлүүлээд
байна

ХУУДАС

6

Орон нутаг:

Дорнод аймаг дахь
Монголбанкны салбарын
үүсэл, хөгжил ба өнөөгийн
байдал

ХУУДАС

10

Мөнгөн тэмдэгтийн түүх:

Манжийн ноёрхлын үеийн
Монголын цаасан мөнгөн
тэмдэгт

ХУУДАС

15

Нийтлэл:

Цахим мөнгө ба
төв банкны ирээдүй

ХУУДАС

16

Инфографик:

Түүхий эд

ХУУДАС

19

Дэлхийн эдийн засаг:

Нарны энерги бол
ирээдүйд хамгийн
тогтвортой эрчим хүч

ХУУДАС

21

Санхүүгийн боловсрол:

Санхүүгийн боловсрол дэлхийд

ХУУДАС

23

Судалгаа:

Судалгааны ажлын тойм: Алтны
зах зээлийн төлөв байдлын
судалгаа

ХУУДАС

27

Ярилцлага:

Дашдондов Баярсайхан “Эрсдэл
багатай банкаар жил дараалан
шалгарч байна”

ХУУДАС

30

Нийтлэл:

Циркуляр эдийн засаг /Circular
economy/, түүнийг Монголд
нутагшуулах асуудлууд

ХУУДАС

34

Нийтлэл:

Эдийн засгийн сэргэлтийн
жилүүдэд Төв банк инфляцийг
хэрхэн “чөдөрлөх” вэ?

ХУУДАС

36

Гадаад валютын ханшийн мэдээг ТҮЦ машинаас авах боломжтой



Төгрөгийн гадаад валюттай харьцах албан ханшийн мэдээллийг ТҮЦ машинаас авах боломжтой. Энэхүү лавлагаа нь дэлхийн 36 улсын валютын төгрөгтэй харьцах тухайн өдрийн болон улирлын дундаж ханшаас гадна алт, мөнгө худалдан авах ханшийн мэдээллийг мөн багтаасан юм. Монголбанкинд иргэн, хуулийн этгээдээс төгрөгийн албан ханшийн лавлагаа авах хүсэлт жилд 1500 орчим удаа ирдэг бөгөөд Монголбанк албан бичгээр хариу хүргүүлдэг байв. Харин ТҮЦ машинаас ханшийн лавлагааг авах боломжтой болсноор иргэдэд мэдээлэл хүргэх үйл явц хялбарчлагдаж, түргэн шуурхай болоод байна.

ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шатны үнэлгээг хийлээ

Гурван жилийн хугацаатай хэрэгжих, улирал тутам үнэлгээ хийгдэх Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний үе шатны үнэлгээг хийх ОУВС-ийн Ажлын хэсэг энэ оны 7 дугаар сарын 19-нөөс 8 дугаар сарын 02-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний хэрэгжилт, тоон үзүүлэлтүүдэд урьдчилсан байдлаар үнэлгээ хийв.



Азийн хөгжлийн банкнаас 100 сая ам.долларын санхүүжилт орж ирлээ



2017 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Азийн хөгжлийн банкнаас 100 сая ам.долларын санхүүжилт Монгол Улсад орж ирж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүллээ. Тус санхүүжилт нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн ажлын хэсгийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний үе шатанд хийсэн үнэлгээний үр дүн эерэг гарч, тус хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагууд болон хөгжлийн түнш орнуудаас батлагдсан 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн дараагийн шатны санхүүжилт хийгдэж эхэлсэн нь энэ юм.

Активын чанарын үнэлгээг хийх компанийг сонгон шалгарууллаа

Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк арилжааны банкуудын активын чанарын үнэлгээг хийх зөвлөх компанийг Монгол Улсын худалдан авах үйл ажиллагааны холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгарууллаа. Сонгон шалгаруулалтын үр дүнд активын чанарын үнэлгээг Бүгд Найрамдах Чех Улсын “PricewaterhouseCoopers” компани хийж гүйцэтгэхээр шалгарсан бөгөөд 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор үнэлгээг хийж гүйцэтгэх юм.



Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.1 тэрбум төгрөг байна



2017 оны 7 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсч 4186.1 тэрбум төгрөгт хүрчээ. Тухайн сард банкууд 661 зээлдэгчид 39.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 4186.1 тэрбум төгрөгт, нийт зээлдэгчдийн тоо 92.1 мянгад хүрэв. Орон нутаг дахь банкууд 238 зээлдэгчид 9.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор орон нутагт ипотекийн зээлийн үлдэгдэл 938.4 тэрбум төгрөгт харин зээлдэгчдийн тоо 29.0 мянгад хүрчээ. 2017 оны 7 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсч 4186.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох Баруун бүсийн сургагч багш нарын сургалт болов

Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын төв, Бичил санхүүгийн хөгжлийн сан хамтран орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг түгээх баруун бүсийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2017 оны 8 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд Ховд, Баян-Өлгий, Увс аймагт зохион байгууллаа. Сургалтад нийт 78 багш хамрагдаж, тухайлсан зорилтод бүлгүүдэд чиглэсэн санхүүгийн мэдлэгийг хэрхэн олгох тухай заах аргад суралцлаа.



МОНГОЛБАНКНААС “МОНГОЛ АЛТ” АЯНЫГ ЭХЛҮҮЛЭЭД БАЙНА

Энэ талаар Монголбанкны “Эрдэнэсийн сан”-гийн захирал П.Эрдэнэтуяатай ярилцлаа.



● “Монгол Алт” аян ирэх гурван сарын хугацаанд хэрэгжих юм байна. Аяны хүрээнд хийгдэх гол ажлууд юу байх вэ?

Монголбанкнаас “Монгол алт” аяныг эхлүүлж байгаа нь “Алт-2” үндэсний хөтөлбөртэй хамааралтай. Энэ хөтөлбөрт Монголбанк алтны худалдан авалтыг нэмэгдүүлж, иргэдэд алтны худалдан авалттай холбоотой мэдээлэл, сурталчилгааг хүргэнэ гэх мэт ажлын төлөвлөгөө тусгагдсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэ нь “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Алт цэвэршүүлэх үйлдвэр”-ийн судалгааг хийх, алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилготой ажлын хэсэг юм. Дээрх ажлуудыг эрчимжүүлэх зорилгоор “Монгол Алт” аяныг эхлүүлсэн. “Монгол Алт” аяныг эхлүүлэх энэ үед манай алт худалдан авалтын дүн 8.9 тоннд хүрээд байна. Алт тушаалтын ид үе 8-10-р сар гэж

үздэг. “Монгол Алт” аяны хүрээнд иргэд, олон нийтэд алт тушаалттай холбоотой мэдээ, мэдээллийг түлхүү хүргэж, алтаа Монголбанкинд тушаахыг уриалах юм.

● Гурван сарын хугацаанд үргэлжлэх аяны үр дүнг хэрхэн харж байна вэ?

Үр дүнгийн хувьд Монгол Улсад алт олборлогч аж ахуйн нэгж, иргэд маань олборлосон алтаа хуулийн хүрээнд Монголбанкиндаа тушаавал дэлхийн зах зээлийн үнээр худалдах, төлбөр тооцоог нь өдөрт нь хийх боломжтой. Мөн алтаа зах зээлийн үнээр Монголбанкиндаа тушааснаар бизнесээ илүү өргөжүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэдгийг бүрэн дүүрэн ойлгосон байх болов уу гэж харж байна.

● Дэлхийн зах зээлийн үнээр алтыг худалдан авч байна гэж байна. Тэгэхээр энэ үнэ гадуур

1999–2009 Москва Комплекс ХХК, Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогч, Ай Эс Си Монголий ХХК, Ерөнхий нягтлан бодогч

2009–2012 Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөл, хянан шалгагч, ЭМДСЗ-ийн нарийн бичгийн дарга

2012 оноос одоог хүртэл: Монголбанк, Төлбөр тооцоо, бүртгэлийн газар, Үндэсний цахим гүйлгээний төв, Төлбөр тооцооны мэргэжилтэн, Тамгын газар, Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Ахлах мэргэжилтэн, Хэлстийн захирал, Газрын захирлын үүрэг гүйцэтгэгч, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар, Эрдэнэсийн сан, Захирал

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

1998: Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Эдийн засагч, нягтлан бодогч

2007: Удирдлагын академи, Удирдахуйн ухааны магистр

2016: Harvard Management Certificate Programm

байгаа ченжүүдийн ч юм уу, худалдан авдаг үнээс хэр ялгаатай байдаг бол?

Өнөөдрийн байдлаар Монголбанкны нэг грамм алт худалдан авах үнэ 101,019.68 төгрөг болж өмнөх өдрүүдээс өссөн байна. Ченжүүд яг ямар үнээр худалдан авдгийг мэдэхгүй. Гэхдээ бидний сонссоноор ченжүүд ойролцоогоор 60-70 мянган төгрөгөөр л авдаг гэж яригддаг.

● Иргэд алтаа тушаахад яг ямар баримт бичиг бүрдүүлж, ямар шат дамжлагаар тушаадаг вэ?

Өнөөдрийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжүүд алтаа сорьцлуулсны дараа Монголбанкинд худалдах боломжтой. Монголбанкны хувьд Үнэт металл, сорьцын хяналтын газрын сорьцолсон бичиг, иргэний үнэмлэх, нэгж, аж ахуйн нэгж бол тухайн аж ахуйн нэгжийн итгэмжилсэн бичиг, мөнгө хүлээн авах дансны

дугаар нэхэмжлэхтэйгээр алтыг худалдан аваад, төлбөр тооцоог нь ямар ч чирэгдэлгүйгээр өдөрт нь шилжүүлдэг.

● Өнгөрсөн жил Монголбанкны алт худалдан авалт 18.3 тоннд хүрч байсан. Энэ жилийн жилийн хувьд алтны худалдан авалт нэмэгдэж байна.

Алт тушаалтын хувьд иргэд түлхүү тушаадаг. Үүнийг бид юутай холбодог вэ гэхээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой гэж хардаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар 3,0 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300,0 сая төгрөг дээр 3,0 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна гэж заасан байгаа. Энэ шатлалаас хамаарч татвараас тодорхой хэмжээнд зайлсхийхийн тулд аж ахуйн нэгжүүд харьцангуй бага

тушааж, иргэд түлхүү алт тушаадаг болов уу гэж хардаг. Нөгөөтэйгүүр 2016 оны сүүлээс эхлэн Лондонгийн үнэт металлын биржийн хамгийн сүүлд зарлагдсан ханш буюу дэлхийн зах зээлийн үнээр алт худалдан авч эхэлсэн нь иргэдийн Монголбанкинд алтаа тушаах сонирхлыг нэмэгдүүлсэн болов уу.

● **Алт тушаагч иргэн байгууллагаас ямар татвар, хураамж авдаг вэ?**

Монголбанкны хувьд иргэн, аж ахуйн нэгж, арилжааны банкнуудаас Монголбанкинд тушааж байгаа алтнаас 2.5 хувийн АМНАТөлбөрийг суутган авч, татварын байгууллагуу шилжүүлдэг.

● **Алт тушаалт гэхээр их хүнд процесс юм шиг ойлгогдоод байдаг. Үүнийг хялбаршуулах боломж байна уу?**

-Бичил уурхайчдын үйл ажиллагааг анзаараад байхад хамгийн гол тулгамдаж байгаа асуудал нь сорьцлолт байгаа юм. 21 аймагт олборлогдож байгаа алтыг зөвхөн Улаанбаатар хотод ҮМХГ-т сорьцлуулсны дараа Төв банкинд тушаах процесс явагддаг. 1963 онд Үнэт металлын чанар шалгах тасаг анх УБЕХороонд байгуулагдсан, 1983 онд Сангийн яамны харьяа байсан, 2008 оноос Стандартчилал хэмжил зүйн газрын харьяанд ажиллаж байгаа. Төв банкны хувьд "Монгол Алт" аяны хүрээнд Монголбанкны дэргэд Үнэт металлын сорьцын лаборатори байгуулах талаар судалж байна. Мөн лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, хэлтсийн аль шаардлагатай аймагт салбар нээх, эсвэл арилжааны банкнуудаар орон нутагт алт худалдан авах ажлыг хийлгэх боломжийг судлан хамтран ажиллах талаар яригдаж байна.

● **"Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах ажлыг судалж байгаа гэлээ. Энэ ажил хэзээ бодитой болох вэ?**

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтарсан ажлын хэсэг маань энэ оны есдүгээр сар гэхэд суурь судалгаагаа боловсруулж дуусгаад, "Алт-2" үндэсний хөтөлбөрт өгөх ёстой. Энэ ажлын хүрээнд бид Швейцарын алт цэвэршүүлэх үйлдвэрийн хүмүүстэй хамтран ажиллаж байна. Мөн манай Төв банкны Судалгаа, статистикийн газрын судлаачид

“ Нөгөөтэйгүүр 2016 оны сүүлээс эхлэн Лондонгийн үнэт металлын биржийн хамгийн сүүлд зарлагдсан ханш буюу дэлхийн зах зээлийн үнээр алт худалдан авч эхэлсэн нь иргэдийн Монголбанкинд алтаа тушаах сонирхлыг нэмэгдүүлсэн болов уу ”

бие даасан судалгаа хийж дууссан. Алт олборлолтын хэмжээнээс хамаараад тухайн улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах нь ашигтай юу, үгүй юу гэдэг судалгаа өмнө нь хийгдэж байсан юм билээ. Ажлын хэсгийн судалгааны үр дүн есдүгээр сард гарна.

● **Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны талаар та мэдээлэл нэмж өгөх үү?**

Монгол Улсын Эрдэнэсийн сан ном хэвлэгдэн гарлаа. Энэ нь Эрдэнэсийн сангийн эд зүйлсийн дэлгэрэнгүй тайлбар бүхий гарын авлага болохоор нэлээд сайн бүтээл болсон, мөн нөгөө талдаа эд зүйлсийн зураг бүхий бүртгэл болох юм. Мөн Эрдэнэсийн сангийн үзмэрийн танхимуудыг шинээр дэглэж, зарим эд зүйлсийг сэргээн засварлан, өнгө үзэмжийг сайжрууллаа. Цаашид ч хийхээр төлөвлөсөн ажлууд их байна.


Ярилцсанд баярлалаа.




Хадгаламж Зээлийн Хоршоо

2017 оны 2-р улирлын байдлаар

Монгол Улсад 1995 онд “Хоршооны тухай” хууль батлагдсанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан ба 1996 онд анхны хадгаламж, зээлийн хоршоо байгуулагдажээ.



Хөрөнгө зээлийн харьцаа - 1:0.77



33.4% Харин үлдсэн 33.4% буюу 96 нь хөдөө, орон нутгуудаар тархан байршдаг



287 - Хадгаламж Зээлийн Хоршоо

Монгол улсад 2017 оны 2-р улирлын байдлаар нийт 287 тооны тусгай зөвшөөрөлтэй ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.



4.8% - Чанаргүй зээл өссөн

Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсөж нийт зээлд эзлэх хувь 4.8 хувьд хүрсэн.



-1.2% - Цэвэр ашиг буурсан

Тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 19.0 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурч 1,597.6 сая төгрөг болсон байна.

Эх сурвалж:
Санхүүгийн Зохицуулах Хороо



ДОРНОД АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Дорнод аймаг дахь Монголбанкны салбарын хамт олон (2017 он)

1925 онд Худалдаа аж үйлдвэрийн банкны Баянтүмэн, Хан-Уулын хошууны 4 дүгээр хэлтэс байгуулагдаж дарга, нягтлан бодогч, нярав зэрэг 6 орон тоотой ажиллаж эхэлснээр тус аймгийн анхны банкны байгууллагын үндэс суурь тавигджээ. Үйлчилгээний хүрээг өргөтгөн 1938 онд Матад, Тамсаг зэрэг газруудад анхны тооцооны касс байгуулагдсанаас хойш 1991 оны 8 дугаар сарыг хүртэл 2 салбар хэлтэс, 22 тооцооны каст мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдан улсын кассын үүргийг гүйцэтгэж байв.

1979 онд бүртгэл гүйлгээ, зээл мөнгөн эргэлт, 1980 онд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлтсүүд байгуулагдсанаар банкны контор болон өргөжсөн юм.

Дорнод аймгийн банкны конторын хамт олон (1982 он)



Улс оронд өрнөсөн ардчилал, өөрчлөлт шинэчлэлтийн дагуу нийгмийн амьдралын тогтолцоо зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж банкны байгууллагын бүтэц задран хоёр шатлал бүхий банкны систем тогтож, 1991 оны 7 дугаар сараас Монголбанкны салбар болж өөрчлөгдөн орон нутагт төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор банкинд хяналт шалгалт хийх, салбар хоорондын тооцоог явуулах, бэлэн мөнгөний эмиссийн үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Дорнод аймгийн банкны нэр, бүтэц дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

Монголбанкны Дорнод аймаг дахь салбарын хамт олон (1995 он)



1925-1991 онуудад

Нэгжийн нэр	Орон тоо	Нэршил, бүтэц өөрчлөгдсөн огноо	Үе, үеийн удирдлагууд
Худалдаа аж үйлдвэрийн банкны Баянтүмэн Хан-Уулын хошууны 4 дүгээр хэлтэс	6	1925 оноос	Балдан (1937)
Худалдаа аж үйлдвэрийн банкны Баянтүмэн хэлтэс	10	1937 оноос	Герасимов (1938) Икаев (1939) Мирошкин (1940) Баранцев (1941-1943)
Худалдаа аж үйлдвэрийн банкны Чойбалсан хэлтэс	13	1942 оноос	Корякин (1944-1945) Семенов П.И (1946-1948) Парначев П.П (1949-1952) Орлов (1953-1954) Жагваралын Жанлав (1954-1955) Гомбын Дугар (1955-1956) Дамдинсүрэнгийн Ядамсүрэн (1957-1958) Жамсранжав (1958-1960) Сундуйн Шагдаржав (1961-1962)
Дорнод аймгийн банкны хэлтэс	10	1962 оноос	Мятавын Дорж (1963-1969) Чинбатын Очирбат (1970-1972)
Дорнод аймгийн банкны контор	95	1979.01.01	Ёндонгийн Төмөр (1973-1990)
1991 оноос хойш			
Монголбанкны Дорнод аймаг дахь салбар	16	1991.09.01	
Монголбанкны Дорнод аймаг дахь салбар	9	1993.01.01	Ёндонгийн Төмөр (1991 он)
Монголбанкны Дорнод аймаг дахь салбар	7	1995.03.01	Гүржавын Лхагва (1991-1999)
Монголбанкны Дорнод аймаг дахь салбар	5	1999.06.04	Аюушийн Жалам (1999-2010)
Монголбанкны Дорнод аймаг дахь салбар	6	2009.07.01	Ядамын Насандэлгэр (2010-2013)
Дорнод аймаг дахь Монголбанкны салбар	6	2014.06.01	Чулууны Тунгалагтуяа (2013-2014) Хажидмаа Алтангэрэл (2014 оноос)

Дорнод аймаг дахь Монголбанкны салбарын хамт олон
(2014 он)



Дорнод аймагт 2017 оны эхний хагас жилийн байдлаар Голомт банк, Хаан банк, Капитал банк, Хас банк, Төрийн банк, Худалдаа, Хөгжлийн Банкны 6 салбар, нийт 43 нэгжээр үйлчилж байгаа бөгөөд тэдгээрт 261 ажилтан ажиллаж, банкны ажил үйлчилгээ, эзэл, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Дорнод аймаг дахь Монголбанкны салбарын хамт олон бид Монгол Улсад банкны тогтолцоо үүсч

бэхэжсэний түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд банкны ахмад ажилтнуудын "Эргэн дурсахуй" цуврал дурсамж нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр сурталчлав.

Банкны үе үеийн ажилтнуудын дурсамж, сэтгэгдлээр бүтсэн, түүхчилсэн "Мөнгөн шастир" номыг анх удаа эмхэтгэн, хэвлүүллээ.

Дорнод аймаг дахь банкны түүхчилсэн лавлахыг жил бүр баяжуулан ажиллаж байна.

Дорнод аймаг дахь Монголбанкны салбар нь Төрийн мөнгөний бодлогыг орон нутагт сурталчлан таниулж, аймаг орон нутгийн удирдлагууд болон тус аймагт үйл ажиллагаа явуулж буй хууль сахиулах болон төр, засгийн байгууллагууд, Дорнод Их Сургууль, Политехникийн Коллеж, МСҮТ, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллаж ирлээ.

Тус салбар нь Төв банк (Монголбанк)-ны үндсэн чиглэл, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хамт олноо манлайлан, 2016 оны орон нутаг дахь Тэргүүний салбараар шалгарсан болно.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН ХУРЛААС... 2017.08.25

Монголбанкнаас сар бүр зарладаг хэвлэлийн бага хурлын асуулт хариултаас хүргэж байна.

Өдрийн сонин: Активын Чанарын Үнэлгээ хийх PWC компанийн Чех улс дахь оффисыг хаанаас, хэн шалгаруулсан бэ?

Хяналт шалгалтын газрын захирал Н.Батсайхан:

Үнэлгээ хийх аудитын компанийг Монголбанк шалгаруулсан. Шалгаруулахдаа олон улсад нэр хүнд бүхий, өмнө нь Активын Чанарын Үнэлгээ хийж байсан туршлагатай компаниудаас сонгосон. Дэлхийд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дөрвөн том компанийн нэг PWC-гийн Чех улс дахь төв оффис шалгарсан.

Засгийн газрын мэдээ: Активын Чанарын Үнэлгээ хийх компани шалгарчихсан байгаа юм чинь үндсэн ажилдаа хэзээ орох вэ?

Активын Чанарын Үнэлгээ хийх үйл ажиллагааг эхлүүлсэн. Гурван сарын дотор гүйцэтгэж дуусах ёстой.

Ийгл телевиз: Активын Чанарын Үнэлгээний шаардлагуудын талаар мэдээлэл өгнө үү?

Үнэлгээний гол баримтлах бичиг баримт нь Европын Төв банкнаас гаргасан Активын Чанарын Үнэлгээ хийх гарын авлага юм. Та бүхэн энэ баримт бичгийг Европын

Төв банкны вэб сайтаас нээлттэй үзэх боломжтой, гэхдээ Монгол Улсын онцлогийг харгалзсан аргачлалаар үнэлгээгээ хийнэ.

Өдрийн сонин: Үйл ажиллагаа явуулахаа больсон хоёр банкыг чанаргүй зээлийн статистиктаа оруулдаг юм уу. Хэзээ татан буугдаж дуусах вэ?

Судалгаа статистикийн газрын Статистикийн хэлтсийн захирал Б.Батсүрэн:

Оруулж байгаа. Өмнө нь гурван банк байсан. Одоо хоёр банк бий.

SBN телевиз: Зээлийн мэдээллийн санд үүрэн телефон болон ломбардны мэдээллийг оруулдаг явдалд иргэд бухимдалтай байна. Энэ талаар тайлбар өгнө үү?

Хяналт шалгалтын газрын захирал Н.Батсайхан:

Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль бий. Тэр хуульд ямар Аж Ахуйн Нэгжүүдийн мэдээлэл байх тухай тодорхой заасан байдаг. Хуулийн дагуу тухайн ААН-үүд аливаа зээлийн үйл ажиллагаа явуулсан бол мэдээлэх үүрэгтэй. Энэ бол хуулийн дагуу л явагдаж буй ажил.

Зээлийн мэдээллийн сангийн журам хэзээ батлагдах вэ. Одоо ямар шалгуураар зээлийн

чанарыг ангилж байгаа вэ?

Зээлийн ангилал активын ангиллын журмын дагуу хийгддэг. Түүний дагуу зээлийн ангилал хийгдэж байгаа. Банкнаас өөр төрлийн санхүүгийн байгууллагуудын зээлийн ангилал өөр биш. Бүгд нэг төрлийн шалгуураар явж байна.

Өдрийн сонин: Хайгуулын лиценз, малыг банкны барьцаанд тавихаа болих асуудлыг ОУВС-аас тавьсан гэсэн мэдээлэл байна. Энэ үнэн үү. Хэрэв үнэн бол энэ нь банкны зээлийн хэдэн хувийг эзэлж байна вэ?

Хөдлөх хөрөнгийн тухай хууль гэж гарсан байгаа. Зарчим нь бол ямар нэгэн үнэ цэнэтэй зүйлийг барьцаалах. Тиймээс лиценз болон малыг барьцаанд авч байгаа.

ОУВС-ийн хөтөлбөрийг хэлэлцэж байхад энэ асуудал яригдаж байсан нь үнэн. Гэхдээ одоо мал болон хайгуулын лицензийг барьцаанд авч байгаа.

Засгийн газрын мэдээ: "Монгол алт" аян ямар шатандаа явж байгаа вэ. Үүнтэй холбогдуулан алт тушаалтын хэмжээ ямар байна?

Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа:

"Монгол алт" аян эхлээд сар гаруй болж байна. Алтны худалдан авалт наймдугаар сарын байдлаар 11.2 тонн болж нэмэгдсэн байгаа. Ойрын үед нэг унци алтны үнэ өссөн.

"Монгол алт" аяны зорилго бол хүнд металлын сорьцлолтын үйл ажиллагааны хүрээнд иргэн, байгууллагад хүндрэлтэй байгаа асуудлуудыг шийдэх, сорьцын хяналтын газрын дүгнэлтийг онлайнаар авдаг болгох, иргэд хүлээлгүй алтаа тушаадаг болгох юм. Монголбанкнаас өглөөний 09:00 цагт алтны үнийг зарладаг, алт худалдан авах үйл ажиллагаа нээлттэй, чирэгдэлгүй явагдаж байгааг иргэдэд мэдээлэх зорилготой.

Өдрийн сонин: Алт тушаалт албан байгууллагаас хувь хүн рүү шилжиж байна гэсэн мэдээлэл байна. Та бүхэнд ямар мэдээлэл байна вэ?

П.Эрдэнэтуяа: Монголбанканд алт тушааж байгаа байдлыг харахад ААН-ээс илүү иргэд идэвхтэй байна.

Өнөөдрийн байдлаар 80 гаруй ААН, 200 гаруй иргэн Монголбанканд алт тушааж байна. Үүнийг бид ААНБ-ын Орлогын албан татварын шатлалтай холбоотой гэж таамаглаж байгаа. Монголбанкны хувьд ямар нэгэн татвар авахгүй. Харин нөөц ашигласны 2.5 хувийн төлбөрийг суутган авч татварын байгууллага руу шилжүүлж байна.

Сорьц нь хүрчихвэл хэн ч алт тушааж болно гэсэн үг үү?

П.Эрдэнэтуяа: Тийм. Иргэн, байгууллага, арилжааны банкууд Монголбанканд алт тушаах нээлттэй.

Засгийн газрын мэдээ: 2018 оны мөнгөний бодлогын төслийг 10 дугаар сард өргөн барина. Бэлтгэл ажил эхэлчихсэн байгаа юу?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа:

Төрийн мөнгөний бодлогын чиглэлийн төслийн бэлтгэл ажил явагдаж байна. Төслийн эхний хувилбар Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооны саналыг авах гээд хүргэгдсэн байгаа. Есдүгээр сарын дундуур Мөнгөний бодлогын зөвлөл, Захирлуудын зөвлөлийн хурлаар төслийн эцсийн хувилбарыг хэлэлцээд УИХ-д өргөн барих төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Блүүмберг телевиз: Чанаргүй зээлийн бүтцэд уул уурхайн компаниуд 25 хувийг эзэлж байна. Нүүрсний үнэ өссөнөөр компаниудын санхүүгийн байдал сайжирч байгаа гэж ойлгож байгаа. Чанаргүй зээлийнх нь хэмжээ буурахгүй байгаа шалтгааныг юу гэж харж байна вэ?

Мөнгөний бодлогыг боловсруулах явцад энэ асуудал яригддаг. Чанаргүй зээлийн төлөв байдал цаашид хэрхэн яаж өөрчлөгдөх вэ гэдэг нь банкуудын зээл олгох, шинээр зээл гаргах чадварт нь нөлөөтэй хүчин зүйл байдаг. Таны хэлснээр чанаргүй зээлийн 20 гаруй хувь нь уул уурхайн салбарт ногдож байна. Энэ чанаргүй зээлийн хэмжээ яваандаа буурна гэсэн хүлээлттэй байгаа. Учир нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн ашигт ажиллагааг харахад II улиралд маш сайжирсан байна. Борлуулалтын цар хүрээ нь тэлж, ашигт ажиллагаа нь сайжирч байгаа нь зээлийн эргэн төлөлтөд нөлөөлнө. Мөн чанаргүй зээлийн ангилал сайжрахад тодорхой хэмжээний хугацаа хэрэгтэй. Хугацааны хувьд 6 сараас дээш зээлээ төлөөд явбал ангилал дээшилдэг.

ХАЛХЫН ДОРНО ЗАМЫН ДУНДАД УМАР ХОШУУГ ЗАХИРАГЧИЙН ТАМГА

Энх-Амгалангийн 31 дүгээр он /1692/

Жин: 3928.0 гр

Өндөр: 11 см, 10.5х10.5 см

Гууль, цутгамал

Тамганы нүүрэнд "Халхын дорно замын дундад умард хошууг захирагчийн тамга" хэмээн Манж, Монголоор нийт дөрвөн мөр бичсэн.

Халхын Дорно замын дундад умард хошуу нь 1692 онд Сэцэн Ханы Хошуунаас тасарч байгуулагдсан бүтэн, хагас сум юм. Улсын Их Дангина Дондогдуламын төрсөн хошууны нутаг бөгөөд Хан Хэнтийн умард хэсэгт "Халхын дорнод дундад дахь умард хошуу" буюу XVII зууны үеэс Хөвчийн жонон гүн, Жонон бэй, Жонон вангийн хошуу хэмээн нэрлэгдэж байжээ. /Дэлгэрэнгүйг Монголбанкны "Эрдэнэсийн сан" номноос.../



МАНЖИЙН НОЁРХЛЫН ҮЕИЙН МОНГОЛЫН ЦААСАН МӨНГӨН ТЭМДЭГТ



Манжийн ноёрхлын үед Монголд Хятадын худалдаа нэвтрэхийн хамтаар Хятадын янз бүрийн пүүсийн "пояз" нэртэй цаасан мөнгөн тэмдэгт орж ирэх болсон агаад үүнээс үндэслэсэн Монголын томоохон сум хийд, зарим хошууд хүртэл иймэрхүү цаасан мөнгийг гарган өөрийн харъяа газар нутагт гүйлгэж лам нарын цалин, өглөг, авлага, худалдаанд хэрэглэдэг Хятад болон Оросын худалдааны пүүсүүдэд зээл мөнгөний барьцаа болгон өгдөг байжээ. Жишээ нь: 1915 онд Цэцэн цэн вангийн хошуу /одоогийн Архангай аймгийн Их тамир, Өндөр-Улаан, Чулуут сум/-ны захиргаа 20000 рублийн хэмжээний тийз гаргасан тухай оросын эрдэмтэн Н.Н.Тугаринов тэмдэглэсэн байна. 1 тийз нь 2.5 копейкой тэнцэж байсан байна. 1 ба 10 гэсэн дэвсгэртэй гарч байсан ба энэ мөнгийг гаргахдаа эмиссийн хууль маягийн журам гарган мөрдөж байжээ. Монголд 19-р зууны 2-р хагасаас товар мөнгөний харилцаа аажим боловч хөгжиж байсан учраас 1860-1870-аад оны

үед орон нутгийн чанартай цаасан мөнгөн тэмдэгт (тийз, зэвд, зоос, тэмдэгт г.м) гарч хэрэглэгдэх болов.

300 ЗООСНЫ ҮНЭЛГЭЭ БҮХИЙ ХҮРЭЭНИЙ ИХ САНГИЙН ТЭМДЭГ

300 зоосны үнэлгээ бүхий Хүрээний их сангийн тэмдэгт нь 1873 оны усан тахиа жил гарчээ. 300 зоосны үнэлгээ бүхий хүрээний их сангийн тэмдэгт нь 130г 90 мм хэмжээтэй муутуу цаасан дээр хар бэхээр барласан байна. Мөнгөн дэвсгэрт дээр 1-р мөрний бичээс дээр жил, өдрийг бичсэн хэсэгт нь дөрвөлжин ба дугуй тамга (улаан өнгөтэй) тус тус дарсан байдаг бөгөөд сүүлийн мөрний хоёр тамга таллан дарагдсан байдаг нь хяналтын тамга байсан бололтой.

(Зургийг илгээсэн) Монголын зоос цуглуулагчдын холбооны ерөнхийлөгч А.Эрдэнэбатын цуглуулгаас

Эх сурвалж: "Монгол Улсын зоос мөнгөн тэмдэгт" Ч.Энхбат, Б.Нямаа, Ц.Батсайхан

\$180,000M

\$160,000M

\$140,000M

\$120,000M

\$100,000M

\$80,000M

ЦАХИМ МӨНГӨ БА ТӨВ БАНКНЫ ИРЭЭДҮЙ



Б.Түмэнцэнгэл
(Монголбанкны ОНБМТ-ийн
Ахлах эдийн засагч)

Цахим мөнгө

Мөнгө бол хүн төрөлхтний хувьд хамгийн чухал зохион бүтээлүүдийн нэг юм. Учир нь мөнгөн тэмдэгт нь арилжаа наймаа хийгдэх, орчин үеийн эдийн засаг оршин тогтнох үндэс суурь болдог. Мөнгө нь төлбөр тооцооны хэрэгслээс гадна, зах зээл дээрх бараа үйлчилгээний үнэ цэнийг хэмжих нэгж, эсвэл хадгалж болох нэг төрлийн хөрөнгө ч болдог. Тэгвэл цаашид мөнгөний эдгээр үүргийг цахим мөнгө гүйцэтгэдэг болох уу гэдэг нэг том асуулт болж байна.

Түүхэнд алт, мөнгө, ховор чулуу гэх мэтийн үнэ цэнэтэй зүйлс, эсвэл ан амьтан, ургац тариа гэх мэт ахуйн хэрэгцээ өндөр, хөрвөх чадвартай зүйлс мөнгөний үүргийг гүйцэтгэх тохиолдол цөөнгүй байв. Тухайлбал торго, халуун ногоо хүртэл худалдаа наймаа хийх үед төлбөрийн хэрэгсэл болж байсан тохиолдлууд дэлхийн түүхэнд бий. Хэвлэлийн технологи сайжирснаар цаасан мөнгө үүссэн ч, анх алтаар баталгааждаг байлаа. Мөнгөний үнэ цэнэ нь итгэл дээр тогтдог гэдгийг хүн төрөлхтөн ойлгосноор сүүлдээ ингэх ч шаардлагагүй болсон юм.

Орчин үеийн эдийн засагт мөнгө нь төв банкны үйл ажиллагаанд итгэх итгэл дээр тогтож байна. Өнөөдөр ихэнх мөнгө биетээр бус, аль хэдийн цахим тоо болчихсон гэхэд болно. Тухайлбал, Их Британид иргэд компаниудын эзэмшиж буй мөнгөний ердөө 4% л зоос эсвэл цаасан дэвсгэрт байна. Харин үлдсэн 96% нь банкны дансанд буюу цахим хэлбэрээр оршдог. Монголын хувьд, манай мөнгөний нийлүүлэлт буюу ойролцоогоор 13 их наяд төгрөгийн ердөө 7% орчим л нэгтээс хорин мянгатын дэвсгэрт байна. Харин үлдсэн нь арилжааны банкуудын компьютерийн санах ойд

хадгалагдаж буй тоо гэж ойлгож болно.

Мөнгө ийнхүү цахим хэлбэрт шилжсэн нь хаях гээгдүүлэх, тээвэрлэх эсвэл шилжүүлэх г.м. олон асуудлыг хялбарчлахын зэрэгцээ, бидний цагийг хэмнэж зардлыг бууруулж буй.

Сүүлийн үеийн чиг хандлага-Биткойн

Технологийн дэвшил, шинэ үеийн хэрэглэгчдийн сонирхол, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхтэй зэрэгцээд мөнгө ч өөрчлөгдөж байна. Одоогийн байдлаар дэлхийн зах зээл дээр нийт 1000 орчим цахим мөнгө арилжаалагдаж, нийт үнэлгээ нь \$160 тэрбум даваад буй. Үүнээс Биткойн дангаараа үнэлгээний тал орчмыг нь эзэлж байгаа бөгөөд, зөвхөн 2017 онд л гэхэд үнэ нь 3 дахин өссөнөөр 8-р сард \$4000 хүрч, нэг унци алтнаас даруй 3 дахин өндөр үнэтэй болсноор хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байна. Цаашид Биткойн мэтийн крипто-мөнгө эдийн засагт маш том хувьсгалыг авчирна гэдгийг онцолж буй шинжээчид ч цөөнгүй.

Уул нь банк санхүүгийн байгууллага г.м. зуучлагч шаардлагагүй, гүйлгээний шимтгэл маш хямд, төлбөр тооцоо хийж буй хүний хувийн мэдээлэл нууцлагддаг, хэн нэгэн зохицуулагчийн зүгээс хяналтгүй зэрэг онцлогууд нь цахим мөнгийг маш шинэлэг зүйл болгосон. Анх зардлаа хэмнэхийг хүссэн жижиг бизнесүүд, өвөрмөц санааг турших сонирхолтой хүмүүс, эсвэл хууль бус, дүрмээс гадуур зүйлсийн наймаанд л цахим мөнгийг ашиглах нь түгээмэл байлаа. 2017 оны эхэнд Кэмбрижийн их сургуулиас хийсэн нэгэн судалгаанд цахим мөнгө хадгалах цахим түрийвч (данс) эзэмшигчдийн тоог 5.8 сая гэж багцаалжээ.

Ялангуяа дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш хөрөнгө оруулах боломжтой активуудын өгөөж буурахын зэрэгцээ Брексит, АНУ-ын сонгууль зэрэг сүүлийн үеийн томоохон улстөрийн үйл явдалтай холбоотой тодорхой бус байдлууд, эрсдэлүүд нэмэгдсэн нь цахим мөнгөний үүрэг ролийг эрс өөрчилж байна. Банкууд, хөрөнгө оруулалтын сангууд, даатгалын

т cap: \$160,565,827,413

Bitcoin market cap: \$72,429M



Ethereum market cap: \$32,877M



компаниуд Биткойнд хөрөнгө оруулж эхэлсэн нь цахим мөнгөний талаарх ирээдүйн төсөөлөл, үнэд ихээхэн нөлөөллөө. Мэргэжлийн хөрөнгө оруулагч нарын энэхүү оролцоо нь цахим мөнгийг төлбөр тооцооны хэрэгслээс хөрөнгө оруулалтын чухал сонголт болж эхэлж буйг илтгэнэ. Харин цаашид цахим мөнгө найдвартай хэрэгсэл байж чадах уу, үнийн савлагаа үүсэхэд эдийн засагт яаж нөлөөлөх вэ зэрэг чухал асуултууд үлдэж байна.

Төв банк ба цахим мөнгө

Өнөөдрийн байдлаар цахим мөнгөний дүн ч, хэрэглэгчдийн тоо ч хараахан эдийн засагт том нөлөө учруулах хэмжээнд хүрээгүй гэхэд болно. Жишээ нь, зөвхөн бэлнээр гүйлгээнд байгаа ам.долларын хэмжээ л гэхэд \$1.5 триллион байгаа нь одоогийн 1000 цахим мөнгийг нийлүүлснээс 10 дахин үнэлгээтэй. Иймд, нэг хэсэгтээ л уламжлалт мөнгөн дэвсгэрт эдийн засагт ноёрхсон хэвээр байх болов уу.

Гэхдээ цаашид энэ байдал яг хэвээрээ байна гэсэн үг биш учраас төв банкууд цахим мөнгийг маш анхааралтай ажиглаж буй. Роланд Бергер зөвлөх компанийн мэдээлснээр бол 2016 оны эцэст 90 орчим төв банк цахим мөнгөний талаар судалгаа явуулж, зарим төв банк ирээдүйд цахим мөнгө гаргах талаар ч хэлэлцэж буй. Цахим мөнгө эдийн засагт үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг олгох ч, төв банкуудын үүрэг ролийг ихээхэн өөрчлөх боломжтой.

Юуны өмнө цахим мөнгөний нэг том давуу тал бол хямд зардал. Мөнгийг үйлдвэрлэхээс эхлээд тээвэрлэх, хадгалах, бохирдож муудсан үед нь устгахад зориулагддаг ихээхэн хэмжээний зардал цахим мөнгө хэрэглэснээр хэмнэгдэх боломжтой. Хөгжсөн орнуудын хувьд бэлэн мөнгөтэй холбоотой зардал ДНБ-ийн 1-2% орчим байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд энэ үзүүлэлт 5-7% хүрдэг. Bank of America мэтийн томоохон сүлжээ банкуудын хувьд бэлэн мөнгийг удирдахтай холбоотой зардал нь жилдээ \$1 тэрбумд хүрдэг гэсэн тооцоо ч бий. Тэгэхээр, хэрэв иргэд түрийвч хэрэглэхээ

болиод АТМ-ээс гар утсан дээрх аппликейшн рүү цахим мөнгөө хуулдаг болвол маш их зардал хэмнэгдэх нь тодорхой.

Харин нөгөө талаас, технологийн компаниуд санхүүгийн үйлчилгээ явуулах, цахим мөнгийг үйлдвэрлээд эхлэхээр төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хяналт, шалгалтын үйл ажиллагаанаас эхлээд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг удирдах үйл ажиллагаа хүртэл оронгоороо эргэх боломжтой.

Түүхийг сөхвөл мөнгөн дэвсгэртийг гүйлгээнд гаргах эрх анх хувийн банкуудад байсан ч, яваандаа төр засагт шилжсэн байдаг. Орчин үед ихэнх улс орнуудад зоос болон цаасан мөнгийг зөвхөн төв банк л гүйлгээнд гаргадаг болсон. Тэгвэл Биткойн мэтийн цахим мөнгийг төв банк эсвэл хэн нэгэн институци дангаараа хариуцаж гүйлгээнд гаргадаггүй нь хамгийн гол онцлог гэхэд болно. Математикийн томъёоны дагуу тусгай кодыг тайлсан хэн ч шинээр цахим мөнгийг гүйлгээнд оруулах боломжтой. Энэ нь төв банкнаас өөр этгээд мөнгө үйлдвэрлэвэл гэмт хэрэгт тооцогддог уламжлалт сэтгэхүйг эвдсэн зүйл юм. Ойрын жишээ гэхэд, Өвөрмонголд Bitmain компани цахим уурхай ажиллуулж, ердөө 50 ажилтан 1 өдөрт \$250 мянган Биткойн олборлон, зах зээлд нийлүүлж байна.


Түүнчлэн, ихэнх цахим мөнгөний үнэ маш тогтворгүй, өндөр савлагаатай байгаа нь найдвартай төлбөрийн хэрэгсэл, үнэ цэнийг хадгалах хөрөнгө оруулалтын хэрэгсэл, үнэ цэнийг хэмжих нэгж болж чадах эсэхэд нь эргэлзээ төрүүлж байгаа. Өөрөөр хэлбэл, цахим мөнгө эдийн засагт мөнгөний үүргийг гүйцэтгэж чадах уу гэдэг асуулт нээлттэй үлдэж буй. АНУ-д гэхэд ам.доллараас өмнө 8000 төрлийн мөнгөн дэвсгэрт байсан ч бүгд энэхүү үүргийг гүйцэтгэж чадалгүй устаж алга болсон. Тэгэхээр өнөөдөр зах зээл дээр байгаа 1000 орчим цахим мөнгөний ирээдүй ямар байх вэ, аль нь амжилт олж аль нь устаж үгүй болох вэ гэдэг хэн бүхний сонирхлыг татаж байна.

Улаанбаатар хотын инфляци 7 дугаар сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2017 оны 7 дугаар сард** улсын хэмжээнд **3.4%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **3.3%-д** хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн





"МОНГОЛ АЛТ" АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монголбанкнаас алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Монгол Алт" аяныг ирэх гурван сарын хугацаанд хэрэгжүүлэхээр болсон бөгөөд аяны нээлтийн үйл ажиллагаа 2017.08.07-ны өдөр боллоо. Энэ үеэр Монголбанкны зүгээс Монгол Улсын "Эрдэнэсийн сан"-г баяжуулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж буй алт тушаагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд "Гэрчлэх бичиг" олгов.

Гурван сарын хугацаанд хэрэгжүүлэх аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгжүүдийг хууль тогтоомжийн дагуу алтыг Төв банкиндаа худалдах, олон нийтийн дунд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт,


сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг танилцуулна.

Мөн Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийг уриалах, тэднийг холбогдох мэдээллээр хангахын сацуу Монголын алтыг хил гаалиар хууль бусаар гаргах ажиллагаа зогсохгүй байгаатай холбоотойгоор Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг иргэд, байгууллагад хүргэх, таниулахыг зорьж байна.


"Монгол Алт" аяныг Монголбанкны төв, орон нутгийн хэлтэс, салбар, арилжааны банкнууд болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх юм.

**Монголбанкны худалдан авсан
алтны хэмжээ, дундаж үнэ**

Үнэ vs Татвараас хамаарал




**2006-2016 онуудад аж ахуйн нэгж, иргэдийн тушаасан
алтны хэмжээ (жилээр)**



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ.ДОЛЛАРААР, 23/VIII ӨДРИЙН БАЙДЛААР)





НАРНЫ ЭНЕРГИ БОЛ ИРЭЭДҮЙД ХАМГИЙН ТОГТВОРТОЙ ЭРЧИМ ХҮЧ

www.weforum.org дээр нийтлэгдсэн нарны эрчим хүчний талаарх нийтлэлийг тоймлон хүргэж байна.

ЯАГААД ГЭЖ ҮҮ?

Хүн төрөлхтөн 1 секундэд 211 тонн нүүрс 1,066 баррель нефть, 93,000 куб метр байгалийн хий хэрэглэж байна.

Эдгээр материал нь XVII зууны үед Их Британид эхэлсэн аж үйлдвэрийн хувьсгалд онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тухайн үед “шинэ эрчим хүч”-ний эх үүсвэр гэгдэж байсан нүүрс болон нефтийг үнэхээр сайн ашиглаж байв. Харин XXI зууны эхэн үед “шинэ эрчим хүч” гэх энэхүү ойлголтыг эргэн харах шаардлагатай болжээ. Амьтан, ургамлын гаралтай шатах ашигт малтмалууд нь манай гаригийн урт хугацааны тогтвортой эрчим хүчний шийдэл болж чадахгүй. Иймд, бид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр орлуулах шаардлагатай. Харин ямар эх үүсвэрээр солих вэ гэдэг асуудал тулгарч байна.

Эрт, орой хэзээ нэгэн цагт нарны энерги нь урт хугацаанд тогтвортой байх цорын ганц эрчим хүч гэдгийг хүн төрөлхтөн ухаарах болов уу? Салхи, цөм, биомасс болон газрын гүний дулаан зэрэг бусад төрлийн


сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй харьцуулахад нарнаас хязгааргүй их хэмжээний эрчим хүчийг хүлээн авч ашиглах боломж бий.

Жишээ нь, хүн төрөлхтөн 2001 онд нэг жилийн хугацаанд бусад бүх эх үүсвэрээс авч хэрэглэсэнтэй тэнцүү хэмжээний эрчим хүчийг ердөө 90 минут хүрэхгүй хугацаанд нарнаас авах боломжтой.

Дэлхийн нийт гадаргуу дээрх нарны боломжит эрчим хүч нь 120,000 Тераватт (ТВт) юм. Хэрэв нарны туяа дэлхийн гадаргын 2% орчмыг 10%-ийн ашигт үйлийн коэффициенттэйгээр бүрхэхэд 50 ТВт эрчим хүчийг үүсгэнэ. Үүнтэй бусад төрлийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн боломжийг харьцуулж үзвэл:

- Салхи 10 метрийн өндөрт 2-4 ТВт,
- 1.5 өдөр болгонд 1 атомын цахилгаан станц барьсан тохиолдолд цөмийн энерги 8 ТВт (Атомын цахилгаан станцын ашиглалтын хугацаа 50 жил),

- Хүнс ургуулах газраа үлдээгээд бусад бүх тариалах боломжтой газрыг ашиглавал биомасс 5-7 ТВт,
- Газрын гүний дулаан 12 ТВт.



Дэлхийн эрчим хүчний өнөөгийн хэрэглээ 17 ТВт байна. Тэгэхээр, дэлхийн гадаргууд тусч буй нарны эрчим хүч нь бидний ашиглах хэрэгцээнээс бараг 10,000 дахин их байна. Хэрэв хүн ам одоогийн хурдаар өсвөл 2050 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээ 30 ТВт хүрэхээр төсөөлөгдөж буй. Хэрэв зөв зохистой ашиглах арга замыг нээж чадах л юм бол нарнаас ялгарах эрчим хүч бидэнд хангалттай хүрэлцэнэ. Иймд бид нарны эрчим хүчин дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Гэхдээ нарны энергийг дулаан, цахилгаан болон шатахуун болгон хувиргасны дараа л сая нэг ашиглах боломжтой болдог тул сорилтыг бий болгож байна. Ер нь сэргээгдэх эрчим хүч нь хүн төрөлхтний цаашдын эрчим хүчний шийдэл болохын тулд хими, биофизик, биологи болон материалын инженер зэрэг олон салбарын мэдлэг огтолцох шаардлагатай нь тодорхой.

Нарны эрчим хүчний хувьд, хар өнгийн хавтангууд

хамгийн өргөн хэрэглэгддэг цахилгаан үүсгэгч болж байна. Хавтангуудыг тунгалаг болгох технологи бидэнд эрс шинэчлэлийг авчрах юм. Учир нь шил л ашиглагдаж байгаа газар цахилгаан үйлдвэрлэгдэх боломжтой болно. Жишээ нь, өндөр шилэн барилгуудын босоо хавтангууд барилгаа бүхэлд нь цахилгаанаар хангадаг эрчим хүчний эх үүсвэр нь болно гэсэн үг. Энэхүү технологийн ачаар төвлөрсөн цахилгаан түгээх сүлжээний хэрэгцээ шаардлага буурах боломжтой болж, хөдөө алслагдсан нутгуудад ч эрчим хүчний асуудлууд шийдэгдэх боломжтой.

Энэхүү санааг Onyx Solar компани аль хэдийн туршиж, 25 оронд хэрэгжүүлсэн 70 барилгын төсөл дээр шилэн барилгуудын цонхыг тунгалаг хавтангаар сольжээ. Харин тус компаний гол өрсөлдөгч болох Ubiquitous Energy компани гар утас, таблетууд г.м. хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр голлон ажилладаг. Цаашид гар утасны шилэн дэлгэц эрчим хүчний эх үүсвэр болсноор батарей буюу цэнэг хураагчийн хэрэгцээ шаардлага буурах боломжтой болох юм.

Түүнчлэн, хиймэл фотосинтезийн аргаар ус төрөгч гарган авах судалгаанууд их хэмжээгээр хийгдэж байна. Байгалийн фотосинтез нь ногоон ургамалууд нарны энергийг ашиглан химийн урвалууд явуулдаг процесс бөгөөд усны молекулыг хүчилтөрөгч болон ус төрөгчийн молекул болгон задалдаг. Хэрэв энэхүү урвалыг хиймэлээр дуурайлгах үр ашигтай аргыг нээвэл бид ирээдүйн түлш гэгдэж буй устөрөгчийг гаргаж авч чадна гэсэн үг.

Тоймлосон: Д.Дуламсүрэн (ОНБМТ-ийн дадлагажигч ажилтан)

Эх үүсвэр: Solar has the brightest sustainable energy future. Here's why (World Economic Forum, 2017)

Financial Literacy

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ДЭЛХИЙД

Энэ цаг үед дэлхийн улс орнуудын хувьд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь эдийн засгийн бодлогын чухал зорилт болоод байна. Учир нь иргэдийн ихэнх нь хувийн санхүүгийн асуудлаа шийдэх чадвар мөхөс байгааг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын (OECD) судалгааны дүн харуулжээ.

Австралид хийсэн судалгаанаас харахад тус улсын иргэдийн 67% нь санхүүгийн боловсролыг дээшлүүлэх бодлогыг дэмжин, нааштай хүлээн авсан бол зөвхөн 28% нь өөрсдийн мэдлэгийг ашиглан энгийн санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх чадвартай байсан юм.

Англи улсын иргэд санхүүгийн тухай мэдээ, мэдээллүүдийг өөрсдийн амьдралд хэрэглэх нь маш бага байдаг ба хаанаас мэдээлэл авч болох талаар ч сонирхдоггүй гэсэн судалгаа гарсан байна. Судалгаанд

оролцогчдын ихэнх нь банкинд дугаарлаж байхдаа брошюраас мөн банкны ажилтнаас санхүүгийн мэдээ, мэдээллүүдийг авдаг гэж хариулсан байна.

Канад улсын иргэдийн хувьд зөв салбарт хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах нь шүдний эмнэлэг явахаас ч илүү дарамттай гэж хариулсан байна.

Солонгос улсын их, дээд сургуулийн оюутнуудын дунд хийсэн судалгааны үр дүнгийн хувьд цочирдом үзүүлэлт гарчээ. Зээлийн картын тухай ойлголт, хэрэглээ, сонголтын талаар судалгаанд оролцсон хүмүүсийн 60-аас бага хувь нь мэдэж байсан бол хуримтлал, тэтгэврийн хадгаламж, даатгалын эрсдэл болон ач тусын талаар тэд бараг юу ч мэддэггүй болох нь судалгаанаас харагдсан байна.

Эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч АНУ-

ын хувьд 10 ажилтны 4 нь тэтгэврийн хадгаламжгүй болохыг мөн тус судалгаа харуулжээ.

Дэлхийн улс орнууд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрт хэрхэн анхаарал хандуулах болсон, мөн тус хөтөлбөрүүдийг ямар арга замаар, хэрхэн яаж хэрэгжүүлж байгаа талаар Австрали, Их Британи, АНУ, Бразил болон БНХАУ-ын жишээн дээрээс авч үзье.



АВСТРАЛИ. Австралийн удирдлагууд анх 2004 онд “Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн юм. Тус улсын Сангийн яам 2011 оны 03-р сарын 15-нд “Санхүүгийн Боловсролыг Дээшлүүлэх Үндэсний Стратеги”-ийг баталсан байна. Тус стратегийн үндсэн чиглэл нь:

- Сургууль, боловсролын институтээр дамжуулан санхүүгийн боловсролыг дээшлүүлэх;
- Үнэн, бодит мэдээллээр хангах;
- Санхүүгийн боловсролын түвшинг тодорхойлон, түүний цаашдын хөгжилд нөлөөлөх шинэлэг бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
- Санхүүгийн боловсролыг иргэдийн дунд үр дүнтэй хэрэгжүүлэн, тэдний санхүүгийн суурь мэдлэгийг сайжруулахын тулд хувийн компаниудтай хамтран ажиллах.

Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд хэд хэдэн томоохон алхмууд хийх саналыг гаргасан байна. Үүнд:

- Хүүхэд, залуус, насанд хүрэгчдэд зориулсан вебсайт ажиллуулах.
- Их, дээд сургууль, төр, төрийн бус байгууллагуудаар дамжуулан иргэдэд зориулсан төлбөртэй болон төлбөргүй санхүүгийн сургалтуудыг зохион байгуулах.
- Иргэдэд санхүүгийн ерөнхий мэдлэг олгох мэргэжлийн багш нар болон сайн дурын сургагч бэлтгэх.
- Австрали улсад санхүүгийн боловсрол хариуцсан санал гомдлын алба (ombudsman – гэж нэрлэдэг) бий болгох.

- Австралийн банкны холбооноос тусгайлан хөтөлбөр гаргах.



ИХ БРИТАНИ. 2011 оны 04-р сараас Их Британид “Мөнгөний зөвлөгөө” гэсэн нэртэй байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Энэ байгууллагын “Хэрэглэгчийн санхүүгийн боловсролын хэлтэс”-ээс хараат бус, санхүүгийн зөв шийдвэр гаргахад тус болохуйц үнэ төлбөргүй зөвлөгөөг залуус, насанд хүрэгчдэд өгдөг. Тус байгууллага нь өөрийн улсын иргэдэд дотоодын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг боловсролыг олгохоос гадна гадаадын улс орнуудын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох үндсэн зорилтыг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Тэргүүлэх чиглэл:

- Залуу эцэг, эхэд зөвлөгөө өгч, тусламж үзүүлэх;
- Сургууль болон бусад боловсролын байгууллагатай хамтран ажиллах;
- Санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хэрэглэгдэх цахим бүтээгдэхүүн бий болгох;
- Мөнгөний хэрэглээний талаар зөвлөгөө өгөх;

Их Британи улс хандив тусламж үзүүлдгээрээ дэлхийд танигдсан улс учир санхүүгийн боловсролыг түгээх ажилд нийгмээс (төр, төрийн бус байгууллага, хувийн компани, корпораци гэх мэт) ирэх дэмжлэг их байдаг.



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС. Нью-Йорк хэмээх дэлхийн санхүүгийн маш том төвтэй улсын хувьд АНУ нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх баялаг туршлагатай улс юм.

Америкийн Сангийн яам 2002 онд Санхүүгийн Боловсролын Газрыг (100% төрийн) байгуулсан.

2006 оноос санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

АНУ-ын санхүүгийн боловсролыг сайжруулах

үндэсний бодлого нь хөгжилтэй орнуудад хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдтэй төстэй. Үүнд:

- Хувь хүний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд илүү анхаарч ажиллах;
- Санхүүгийн холбогдолтой асуултад хариу өгөх утас ажиллуулах;
- Сургуулийн насны хүүхдэд санхүүгийн боловсрол олгох — гэсэн үндсэн чиглэлийг баримталдаг байна.

АНУ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мэдэгдэхүйц үр дүн гарсан. Санхүүгийн боловсролын түвшин тус улсад өндөр ба хүүхэд 10 нас хүрмэгцээ банкны карт эзэмших эрхтэй болдог байна. Ихэнх мужид бэлэн мөнгөний хэрэгцээ багассан ба иргэдийн санхүүгийн мэдлэг сайжирч байгаа нь тэдний амьдралдаа тулгарч буй санхүүгийн асуудлаа хэрхэн шийдвэрлэж байгаагаас нь харж болно.

АНУ-ын их, дээд сургуулиудад “Санхүүгийн төв” ажилладаг бөгөөд оюутнууд суралцаж байх хугацаандаа мөн төгссөнийхөө дараа ч тус төвөөс санхүүгийн зөвлөгөө авч болдог байна.



БРАЗИЛ. Бразил Улс иргэдийнхээ санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч залууст чиглэсэн үйл ажиллагааг түлхүү явуулдаг. Засгийн газрын хэмжээнд одоогоор “Санхүүгийн Боловсролын Түвшинийг

Дээшлүүлэх Үндэсний Стратеги”-ийг хэрэгжүүлж байна. Учир нь тус улсын иргэдийн 82% нь банкнаас авсан зээлийнхээ хүүгийн хэмжээг мэдэхгүй, 87% нь хадгаламжгүй буюу маш бага хэмжээний хадгаламжтай гэсэн судалгаа гарсан байна.

“Санхүүгийн Боловсролын Түвшинийг Дээшлүүлэх Үндэсний Стратеги”-ийн онцлог нь нийт иргэдэд чиглэсэн байдаг. Тухайлбал:

- Сургуулийн насныханд зориулсан санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг багтаасан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд сурагчдад заах хичээлийн ном, сурах бичгийг Бразил Улсын Төв банкнаас боловсруулан гаргаж, хичээл заах багш нарыг

бэлдэх;

- Бүх насныханд зориулсан гарын авлага, ном, сурах бичиг, хүүхэлдэйн кино, шторк зэргийг боловсруулах гэх мэт ажил энэхүү стратегид багтсан байна.

Дээр дурдсан ажлуудыг 2010 онд хийж гүйцэтгэн, анх иргэдэд танилцуулан, сургалт явуулахад 30.000 иргэн хамрагдсан тоо баримт байдаг байна. Тус улсын Засгийн газраас энэхүү төслийг маш амжилттай хэрэгжсэн төсөл хэмээн авч үздэг.

Насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд цэргийн албан хаагчид, багш нар, мөн төрийн албан хаагчдад зориулсан тусгай хөтөлбөр, сургалтууд зохион байгуулах тал дээр илүү анхаарч ажилладаг байна.



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД

АРД УЛС: БНХАУ нь Бразил Улсын нэгэн адил санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны гол зангилааг тус улсын төр нь авч явдаг. БНХАУ-д одоогоор хэрэгжиж

буй санхүүгийн боловсрол олгох цогц хөтөлбөр байхгүй ч, сурагчид, оюутнуудад зориулсан “Санхүүгийн Боловсрол Олгох Хөтөлбөр” байдаг байна. Тус хөтөлбөрийг БНХАУ-ын Боловсролын яам, Сангийн яам хамтран баталсан байдаг. Хөтөлбөрийн зорилго нь:


- Санхүүгийн боловсролыг хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан үе шаттайгаар олгох;
- Сургалтын төлбөрийн зээлтэй холбоотой асуудал тулгараад буй оюутнуудад тусламж үзүүлэх.

Үүнээс гадна дээр дурдсан хоёр яам хамтран Бээжингийн Их Сургуулийн харъяа сургалтын төв нээсэн. Энэ төв нь эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгаа явуулахаас гадна иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулдаг байна. Эдгээр сургалтын хөтөлбөрүүдийг дэлхийн санхүүгийн боловсролын чиг хандлага болон Хятад улсын нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулан боловсруулдаг юм.

Орчуулсан: Х.Солонго
(ОНБМТөвийн дадлагажигч ажилтан)



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



ДНБ гэж юу вэ?

Тодорхой хугацаанд тухайн оронд шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл Дотоодын нийт бүтээгдэхүүнд тухайн улсын хил дотор байгаа бүх үйлдвэрлэлийг оруулж тооцно.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн гурван аргаар тооцдог.



Монгол улсын ДНБ-ний хэмжээ 2016 оны байдлаар 23.8 их наяд төгрөг байна. Үүнээс Уул уурхайн салбар 20 хувийг, Хөдөө аж ахуйн салбар 12 хувийг, Худалдааны салбар 11 хувийг тус тус эзэлж байна.




Нэрлэсэн ДНБ гэдэг нь тухайн жилд тус улсын эдийн засгийн газар нутаг дээр үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг тайлант оны үнээр илэрхийлснийг хэлдэг.

Жишээлбэл, 2002 онд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг 2002 оны үнээр илэрхийлсэн бол 2002 оны нэрлэсэн ДНБ болно.

Бодит ДНБ гэдэг нь тухайн жилд тус улсын эдийн засгийн газар нутаг дээр үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг суурь оны үнээр илэрхийлснийг хэлдэг.

Жишээлбэл, 2002 онд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг 1995 оны үнээр илэрхийлбэл 2002 оны 1995 оны үнээр зэрэгцүүлсэн бодит ДНБ болно




Ранк	Дэлхийн топ 10	ДНБ /тэрбум \$/	Монгол Улсын Эдийн засгаас хэд дахин том бэ?	Ранк	Азийн зарим орнууд	ДНБ /тэрбум \$/	Ранк	Монголын "өрсөлдөгчид"	ДНБ /тэрбум \$/
1	Америк	16,768.1	1,456	14	Солонгос	1,304.6	121	Ямайк	14.4
2	Хятад	9,240.3	802	16	Индонези	868.3	122	Конго	14.1
3	Япон	4,919.6	427	30	Тайланд	387.3	123	Чад	13.5
4	Герман	3,730.3	324	35	Малайз	313.2	124	Зимбабве	13.5
5	Франц	2,806.4	244	36	Сингапур	297.9	125	Намиби	13.1
6	Их Британи	2,678.5	233	39	Хонг Конг	274.0	126	Албани	12.9
7	Бразил	2,245.7	195	40	Филиппин	272.1	127	Маурити	11.9
8	Итали	2,149.5	187	46	Казакстан	231.9	128	Өмнөд Судан	11.8
9	Орос	2,096.8	182	57	Вьетнам	171.4	129	Буркина Фасо	11.6
10	Энэтхэг	1,876.8	163	168	Бутан	1.8	130	Монгол	11.5

АЛТНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА


Дэлхийн алтны зах зээлийн эрэлт

Дэлхийн алтны эрэлтийг үнэт эдлэл; технологи, аж үйлдвэр; хөрөнгө оруулалт; төв банкны гэсэн 4 үндсэн хэсэгт ангилж болно. Эдгээрээс дийлэнх хэсгийг үнэт эдлэл болон хөрөнгө оруулалтын зориулалттай алтны эрэлт эзэлж байна. Сүүлийн 7 жилийн дэлхийн алтны эрэлтийг авч үзэхэд 2011 онд өмнөх оноос 12.4%-иар огцом өсч 4739.2 тоннд хүрснээс хойш 2015 он хүртэл тасралтгүй буурсан байна. Харин өнгөрсөн 2016 онд 1.62%-иар өсч 4315.0 тонн болжээ. Алтны эрэлтийг үндсэн ангиллуудаар авч үзье:

Дэлхийн алтны зах зээлийн эрэлт
/зориулалтаар, тонн/



Үнэт эдлэлийн зориулалттай алтны эрэлт
/улсуудаар, тонн/



Эх сурвалж: Эх сурвалж: Metals Focus; Thomson Reuters; ICE Benchmark Administration; World Gold Council

Төв банкуудын худалдан авалт

Төв банкууд нь өөрсдийн нөөцийн тодорхой хэсгийг алт хэлбэрээр бүрдүүлдэг тул дэлхийн алтны эрэлтийн тодорхой хэсгийг бий болгож байдаг. Хамгийн их алтны нөөцтэй төв банкуудын алтны хэмжээ болон нийт нөөцөд эзлэх хувийг дараах хүснэгтэд харуулав:

Хамгийн их алтны нөөцтэй төв банкнууд /улсаар/


№	Улс	Тонн	Нийт нөөцөд эзлэх хувь	№	Улс	Тонн	Нийт нөөцөд эзлэх хувь
1.	АНУ	8,133.5	75.0%	5.	Хятад	1,842.6	2.4%
2.	Герман	3,375.6	69.6%	6.	ОХУ	1,706.8	17.1%
3.	Итали	2,451.8	67.4%	7.	Швейцари	1,040.0	5.6%
4.	Франц	2,435.9	64.9%	8.	Япон	765.2	2.5%

Эх сурвалж: International Financial Statistics, July 2017

Алт нийлүүлэгч улс орнууд

Шинээр олборлогдож байгаа дэлхийн нийт алтны 23% нь Ази тивд, 19% нь Төв болон Өмнөд Америкт тивд, 16% нь Хойд Америкт, 14% нь Африк тивд үйлдвэрлэгдэж байна.

Алтны нийлүүлэлт, улс орнуудаар /2016 он, тонн/



Эх сурвалж: World gold council

Алт нийлүүлэгч олон улс байдаг ч нийт нийлүүлэлтийн тал хувийг зургаан улс бүрдүүлдэг. Дэлхийн томоохон алт нийлүүлэгч гэдэгт БНХАУ, Австрали, ОХУ, АНУ болон Канад зэрэг улсуудыг нэрлэж болохоор байна.

Алтны үнийн түүхэн тренд

Алтан стандартын уналтаас хойш алтны үнэ хэрхэн өөрчлөгдсөн, түүнд ямар үйл явдлууд нөлөөлсөн талаарх мэдээлэл нь алтны үний хэлбэлзлийг тайлбарлахад чухал юм.

Алтны урт хугацааны түүхэн үнэ (сар, доллар/унц)



Эх сурвалж : Bloomberg

Алтны үнэд нөлөөлж байсан зарим гол үйл явдлыг илүү дэлгэрэнгүй байдлаар тайлбарлавал:


Алтны зах зээлийн түүхэн үйл явдлын тойм (сар, доллар/унци)

Он сар	Үйл явдал	Тайлбар	Үр дүн
1971-8 сар	Алтан стандартын үе дууссан.	АНУ алтыг долларт тогтсон үнээр (\$35/унц) ахин арилжаалахгүй гэдгийг зарлаж, алтан стандартыг халсан.	Алтны үнэ тогтвортой өсөх үйл явдлын эхлэл болсон.
1980-1 сар	Иран улсын хувьсгал, газрын тосны үнэ өссөн.	Геополитикийн тодорхойгүй байдал ба инфляцийн өсөлтөөс шалтгаалан хөрөнгө оруулагчид алтыг аюулгүй байдал хэмээн нэрлэж эхэлсэн.	Үнэ нь \$850-т хүрсэн.
1999-8 сар	Төв банкнууд алтны нөөцөө борлуулж эхэлсэн.	Төв банкнууд алтны нөөцөө валют шиг борлуулж эхэлсэн.	Үнэ нь \$251.70-руу буурсан.
2008-9 сар	Lehman Brothers банк дампуурсан.	АНУ засгийн газар Lehman Brothers банк дампуурсныг зарласнаар Төв банкнууд алтны нөөцийг эргүүлэн бий болгосон.	Үнэ нь \$878.75-руу өссөн.
2011-9 сар	Европын орнуудын өрийн дарамтад орсон.	Европын орнууд өрийн дарамтад орсноор хөрөнгө оруулагчид өөрсдийн мөнгөө алтанд хөрвүүлж эхэлсэн.	Үнэ нь \$1921.4-т хүрсэн.
2015-8 сар	Айдас багассан.	Өрийн дарамтын айдас багассанаар алтны үнэ огцом буурч эхэлсэн.	Үнэ нь \$1094.15-руу буурсан.
2016-7 сар	Brexit	Нэгдсэн Вант улс Европын холбооноос гарсан.	Үнэ нь \$1358.20-руу өссөн.

Эх сурвалж : Schrodgers. RC60853

Монголын Улсын алтны экспорт

Алт нь Монгол улсын экспортын орлогыг бүрдүүлэгч чухал үнэт металл юм. Энэхүү үнэт металлын экспортын орлого 2016 онд 600 сая ам.доллар давсан нь 2008 оноос хойш анх удаа бөгөөд сүүлийн 9 жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 758 сая ам.долларт хүрээд байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголбанкны Судалгаа, статистикийн газар



ДАШДОНДОВ БАЯРСАЙХАН "ЭРСДЭЛ БАГАТАЙ БАНКААР ЖИЛ ДАРААЛАН ШАЛГАРЧ БАЙНА"

Та Санхүүгийн зохицуулах хороонд олон жил ажилласан. Харин одоо банкны системд ажиллаж байна. Манай улсын санхүүгийн зах зээлийн гол тулах багана банкны системийн "эрүүл мэнд"-ийн байдлыг хэрхэн харж байна вэ. Энэ талаар ярилцлагаа эхлэх үү?

Юуны өмнө танай сэтгүүлийн уншигчдад энэ өдрийн мэндийг хүргэе. Банкны системийн үнэлгээг сайн, муу гэж шууд дүгнэх нь учир дутагдалтай. Гэхдээ хувь хүний

бодлыг асууж байгаа бол надад байгаа мэдээллээр өнөөдөр манай банкны системийн "эрүүл мэнд" дунд зэргийн байна л гэж хэлнэ. ОУВС-гаас арилжааны банкуудын Активын чанарт хийгдэж буй үнэлгээний дүгнэлт гарахад банкны системийн эрүүл мэнд яг ямар байна вэ гэдэг бодит дүн харагдах болов уу гэж бодож байна. Ер нь банкны системийн эрүүл мэндийн байдал макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй шууд холбоотой. Өнгөрсөн жилүүдэд Монгол улсын макро эдийн засагт таагүй хандлага

Дашдондов БАЯРСАЙХАН

Төрийн банкны Ерөнхий захирал

АЖЛЫН ТУРШЛАГА

1996–2004 он: Хууль Зүй дотоод хэргийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтэс, газрын дарга

2006–2015 он: Санхүүгийн зохицуулах хорооны дарга

2015 оны 04–11 сар: Зээлийн батлан даалтын сангийн захирал
2016 оны есдүгээр сараас эхлэн Төрийн банкны Ерөнхий захирал

ГИШҮҮНЧЛЭЛ

1997–2004 он: Төрийн өмчийн хорооны гишүүн

1998–2006 он: Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүн

2006–2015 он: Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн

2016 оны 12 сараас МБХ-ны Дэд ерөнхийлөгч

үргэлжилснийг хэн хүнгүй мэдэж байгаа. Үүнийг дагаад банкуудын эрүүл мэндийн байдал нэг үеийг бодвол харьцангуй суларсан. Гэхдээ сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засагт олон эерэг өөрчлөлт, хандлага гарч эхэлсэн. Үүнтэй холбоотой банкны системд эерэг үзүүлэлтүүд гарч эхэллээ. Төрийн банкны хувьд бол төлбөр түргэн гүйцэтгэх чадвар өндөр, ашигт ажиллагаа боломжийн, активын чанар сайн байгаа. Төрийн банк нь санхүүгийн зах зээлд үйл ажиллагаагаа

өргөтгөн, Монгол улсын нийслэл, аймаг сум, дүүрэг бүрт байршсан салбар, нэгжээрээ дамжуулан нийт 2,7 сая харилцагчдаа банк, санхүүгийн цогц үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Нэгэнт Монгол Улс зах зээлийн нийгмийг сонгосон хойно бидний авч хэрэгжүүлж байгаа бодлого үйл ажиллагаа дэлхийн стандартыг дагах нь зүйн хэрэг биз. Үүгээр би юуг сонирхож байна вэ гэхээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн банкны бүртгэлийн стандартууд манайд хэр мөрдөгддөг байгаа, санхүүгийн бүртгэл үнэн бодитоор тэмдэглэгдэхийн ач холбогдлыг тодруулж асуумаар байна?

Бид зах зээлийн нийгэмд шилжээд 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Монголын бүхий л салбар олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, стандартыг хангахыг зорьж ажиллаж ирлээ. Энэ дундаас боловсон хүчний, бодлогын, техник хангамж, хийгдсэн хөрөнгө оруулалтын хувьд олон улсын стандартад дөхсөн үйл ажиллагаа явуулж байгаа нь ямар ч маргаангүй банкны салбар юм. Банкууд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэлийн үйл ажиллагаагаа зохион байгуулж, мөрдөж ажиллаж байгаа.

Санхүүгийн бүртгэл үнэн бодитой байх нь өндөр ач холбогдолтой. Банк нь дүрмийн сан буюу хөрөнгө оруулагчдын хөрөнгөөс гадна харилцагчдын итгэлд тулгуурлан, тэдний мөнгөн хөрөнгөөр голлож бизнес хийдэг

байгууллага. Харилцагчид итгэж мөнгөө хадгалуулсан, итгэж харилцаж байгаа байгууллагынхаа үйл ажиллагааг ямар байгааг үнэн зөв, ил тод мэдэж байх эрхтэй. Тийм ч учраас хуулиар арилжааны банкууд санхүүгийн тайлангаа улирал, жилээр олон нийтэд ил тод мэдээллэж байх, жил бүр хөндлөнгийн хяналтын байгууллагаар аудит хийлгэж байх зохицуулалтыг хийж өгсөн байдаг. Банкууд ч хуулийн хүрээнд тайлангаа ил тод тавьж, аудитаа хийлгэж нэгэнт хэвшсэн.

Харилцагчдын итгэлийг даана гэдэг арилжааны банкны хувьд хамгийн чухал. Энэ үзүүлэлт танай банкинд ямар түвшинд байгаа талаар мэдээлэл өгнө үү?

-Төрийн банк байгуулагдсан цагаасаа эрсдэлгүй үйл ажиллагаа явуулах бодлого барьж ажиллаж ирсэн. Тэр утгаараа активын чанарын үзүүлэлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар манай банкны хувьд өндөр байдаг. Бид ашигт ажиллагаанд анхаарахаас илүү эрсдэл багатай үйл ажиллагаа явуулах чиглэлд түлхүү анхаарал хандуулж ажилладаг. Бид банкиг эрсдэлгүй, найдвартай, шуурхай ажиллагаатай байлгах зорилт тавьж, дотоод хяналтаа сайжруулан ажилласны үр дүнд арилжааны банкуудаас эрсдэл багатай банкаар жил дараалан шалгарч байна.

Төв банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа нь гүйцэтгэлд суурилдаг байснаа эрсдэлд суурилдаг болсон. Үүнийг арилжааны банкны өнцгөөс хэрхэн дүгнэж байна вэ?

“Банкны үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянахаас илүү эрсдэл хаана, ямар хэмжээтэй байна вэ, тэрхүү эрсдэлийг хэрхэн хянаж, удирдах вэ гэдэгт анхаардаг, зохицуулдаг систем руу явж байна.”

-Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагаанд шилжих асуудал нэлээд хэдэн жилийн өмнөөс яригдаж эхэлсэн. Олон улсын хяналт шалгалтын байгууллагаас ч хяналт шалгалтын үйл ажиллагаа гүйцэтгэлд биш эрсдэлд чиглэсэн байх ёстой гэдэг шаардлагыг тавьж ирсэн. Энэ зөв. Сүүлийн үед банкууд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг болсон учраас урьдынх шигээ гүйцэтгэл бүрийг хянахад хүндрэлтэй болсон. Тиймээс банкны үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянахаас илүү эрсдэл хаана, ямар хэмжээтэй байна вэ, тэрхүү эрсдэлийг хэрхэн хянаж, удирдах вэ гэдэгт анхаардаг, зохицуулдаг систем руу явж байна. Төв банкнаас арилжааны банкуудад тавьж байгаа хяналт шалгалт эрсдэлд суурилдаг болсноос гадна тухайн банк дотоод үйл ажиллагаагаа мөн дээрх системээр

хянах чиглэлийг баримталж байна. Төрийн банкны хяналтын систем ч энэ чиглэлд явж байгаа.

ОУВС-гийн хөтөлбөр санхүүгийн зах зээлд хэрхэн нөлөөлж байна вэ, тэр дундаа банкны салбарт ямар өөрчлөлт харагдаж байна?

-Валютын сангийн хөтөлбөрийн гол зорилго бол санхүүгийн хариуцлага сахилга батыг тогтоох гэж харж байгаа. Өнгөрсөн жилүүдэд Монгол Улс 3-4 төсөвтэй, төсвөөс гадуур олон тэрбумын зарлага гаргадаг болсон нь санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сулруулсан буруу жишиг байсан. Валютын сангийн хөтөлбөрийн гол зорилго бол өнгөрсөн жилүүдэд гаргасан алдааг арилгах, буруу жишгийг арилгах, ирээдүйд Монгол Улсын санхүүгийн салбарын сахилга батыг сайжруулах юм. Санхүүгийн сахилга бат сайжрахын хэрээр Монгол Улсын эдийн засаг мэдэгдэхүйц сайжирч төсвийн орлого биелж, валютын ханш тогтворжиж эдийн засгийн өсөлт 5.3 хувь хүрсэн нь багагүй амжилт. Энэ бүх эерэг хандлага банкны салбарт эерэгээр нөлөөлж, эхний үр дүн гарч байна. ОУВС-гийн хөтөлбөрийн нэлээд том хэсэг нь магадгүй банкны салбарт хийгдэж байгаа активын чанарын үнэлгээ байх. Үүний дараа банкууд хаана байна вэ, цаашдаа юу хийх вэ гэдэг нь илүү тодорхой

болно гэж бодож байгаа.

Зээлийн хүү өндөр байна гэх шүүмжлэл дагуулсан асуулт байна. Зээлийн хүүг бууруулах боломжийг банкууд эрэлхийлж байгаа. Энэ тал дээр ямар байр суурь илэрхийлэх вэ?

-Зээлийн хүүг бууруулна гэхээсээ өмнө банкны зээлийн хүүнд ямар фактор нөлөөлж байгааг заавал ярих хэрэгтэй болно. Харилцагчдаас татсан эх үүсвэрийн өртөг, үйл ажиллагааны зардал, тооцоолсон ашиг гурвын нийлбэрээр харилцагчдад олгож байгаа зээлийн хүүгийн хэмжээг тогтоодог. Энэ гурван хүчин зүйлийг анхаарч ажиллаж байж зээлийн хүү буурна. Үйл ажиллагааны зардлаа банкууд бууруулж байгаа. Харин ашигт ажиллагааны хэмжээг ч мөн буулгах боломжтой. Зээлийн хүүнд хамгийн их жин дардаг нь эх үүсвэрийн өртөг буюу харилцах, хадгаламжийн хүү юм. Зээлийн хүүг буулгахад хамгийн түрүүнд хадгаламж, харилцахын хүүг буулгах хэрэгтэй болно. Мэдээжийн хэрэг зээлийн хүү бага байх нь зөвхөн харилцагчдад ч бус банкинд ч ашигтай. Зээлийн хүү бага байвал эрсдэл багасана. Тэр утгаараа зээлийн хүүг буулгах сонирхол банкуудад ч бий. Гэхдээ гол асуудал бол эх үүсвэрийн өртөгийг л яаж бууруулах вэ гэдэг асуудал байгаа. Бага өртөгтэй эх үүсвэр татаж чадвал мэдээж зээлийн

хүү буурна. Түүнээс биш хүчээр зээлийн хүүг буулгах боломжгүй. Дунджаар жилийн 15 хувийн хүүтэй эх үүсвэр татчихаад 10 хувиар зээл олговол зөрүүнээс үүсэх алдагдлыг хэн хүлээх вэ гэх асуудал гарна. Төр алдагдлыг үүрнэ гэвэл эргээд татвар төлөгчдийн нуруун дээр ачаа нэмэгдэнэ шүү дээ.


Манай банкны салбарт гадаадын банк үйл ажиллагаа явуулснаар эрүүл өрсөлдөөн бий болно гэж ярьж байна. Таны хувьд энэ тал дээр ямар бодолтой байна вэ?

-Олон жил яригдаж байгаа асуудал. Гол нь аливаа зах зээл өрсөлдөөн дээр тогтдог. Энэ ч утгаараа хаана эрэлт байна тэнд л шаардлагатай, дутагдалтай байгаа нийлүүлэлт хийгдэх учиртай. Юу гэсэн үг вэ гэвэл, манай банкуудын хүрч чадахгүй байгаа томоохон хөрөнгө оруулалт шаардсан төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тал дээр яагаад гадны банк ажиллаж болохгүй гэж. Харин эсэргээрээ арилжааны банкуудын нэгэнт бий болгосон зах зээлийг буюу дотоодын банк санхүүгийн тогтолцоог хамгаалах бодлого байх болов уу гэж бодож байна. Өөрөөр хэлбэл холбогдох хязгаарлалтыг зохих түвшинд хийсэн, хууль эрх зүйн орчныг нь бий болгоод гадны банк оруулах нь зөв гэж боддог. Бусад улс оронд болоод л байна.



Үнэт Цаасны Зах Зээл

2017 оны 2-р улирлын байдлаар



1 497 Тэрбум Төгрөг

Зах зээлийн нийт үнэлгээ /637 сая ам.доллар/

Эх сурвалж:
Монголын Хөрөнгийн Бирж



220 Хувьцаат Компани

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 220 ХК байдаг ба тэдгээрийн компанийн засаглал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэж 3 самбарт ангилдаг



58 Брокер Диллерийн Компани

Монголын Хөрөнгийн Биржид 58 үнэт цаасны компани бүртгэлтэй байдаг

32.9K

МХБ-ийн шилдэг 20 компанийн хувьцааг нэгтгэн "ТОП 20" индексийг тооцдог аж. Түүхэн дээд хэмжээ 2011 оны 2-р сарын 27-нд 32955 нэгжид хүрч байсан бол 2017 оны 6-р сарын 30-ны байдлаар 12725.82 нэгж дээр хаагдсан байна.





ЦИРКУЛЯР ЭДИЙН ЗАСАГ /CIRCULAR ECONOMY/, ТҮҮНИЙГ МОНГОЛД НУТАГШУУЛАХ АСУУДЛУУД

УИХ-ын гишүүн, эдийн засгийн
ухааны доктор Б.Баттөмөр

УИХ-ын гишүүн, эдийн засгийн ухааны доктор Б.Баттөмөрийн циркуляр эдийн засгийн тухай бичсэн нийтлэлийг хүргэж байна. Тэрээр Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжээд 27 жил өнгөрч байгаа боловч төсвийн орлого бага, зарлага нь оновчгүй, эдийн засгийн боломжийг бүрэн дайчилж чадахгүй, төсвийн сахилга бат муу байгааг УИХ-ын индэр дээрээс хэлж буй гишүүдийн нэг юм. Б.Баттөмөр нь өнгөрсөн хугацааны алдаан дээрээс сургамж авч эдийн засгийн загвараа шинэчилж, шинэ эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг. Шинэ эдийн засгийн бодлогын хүрээнд маш олон асуудлыг дэвшүүлж байгаагийн нэг нь циркуляр эдийн засаг юм.

Циркуляр эдийн засгийн концепцыг анх Британийн эдийн засагч Дэвид Пирс, Керри Тернер нар боловсруулсан түүхтэй. Хөгжингүй орнууд, тэр дундаа Европын Холбоо, Англи, Австрали зэрэг орнууд энэхүү эдийн засагт шилжихэд онцгойлон анхаарч байна. Циркуляр эдийн засаг гэдгийг тойрог, эргэлтийн, шугаман бус эдийн засаг гэж орчуулж болох юм.

Бизнес эрхлэгчдийн хувьд циркуляр эдийн засаг

нь илүү их ашиг, орлого авчрах боломжтой бөгөөд үндсэн санаа нь ашиглаж дууссан зүйлсийг дахин боловсруулах, дахин сэргээж эцэст нь тултал ашиглахыг дэмжихэд байгаа юм. Ингэснээр ажлын шинэ байрууд нэмэгдэнэ, түүхий эд, материал, эрчим хүчний хомсдол арилна, байгаль орчинд учруулах хор хохирол багасна. Үндсэндээ хог хаягдал гэж байхгүй болох ажээ.

Хамгийн гол нь ирээдүй хойчдоо аюулгүй, байгалийн бохирдолгүй, эрүүл саруул орчныг үлдээхэд циркуляр эдийн засаг маш чухал үүрэгтэй.

Циркуляр эдийн засагт шилжсэнээр баялгийн шинэ эх үүсвэрийг бий болгож, инновацийн шинэ загварууд аж үйлдвэр, хотууд, суурин газруудад нэвтэрч, тогтвортой нэмүү өртгийг бий болгож, бүтээгдэхүүн борлуулахын оронд үйлчилгээг худалдаж, хог хаягдлаас мөнгө, баялаг үүсгэнэ. Циркуляр эдийн засаг улс орнуудын өрсөлдөх чадварыг улам нэмэгдүүлж, нийгмийн гишүүн бүрт ашгаа өгнө. Аж үйлдвэрт дахин боловсруулсан материалыг ашиглах болно.

Өнгөрсөн хугацаанд хүн төрөлхтөн асар их баялгийг хуримтлуулсан бөгөөд үүний ихэнхийг байгалийн

баялгийг ашиглан бүтээсэн байдаг. Байгалийн баялаг нэгэн цагт дуусах нь тодорхой. Байгалийн баялгийг ашиглаад хог хаягдал болгоод газарт булаад байвал цаашид юу болох вэ гэдэг нь ойлгомжтой. Үүнээс гарах гарц нь циркуляр эдийн засагт шилжих явдал юм гэдэг дээр эрдэмтэд санал нэгдээд байна.

Судалгаанаас үзэхэд циркуляр эдийн засгийг хөгжүүлж, технологийн хувьсгал хийснээр байгалийн баялаг ашиглалтын бүтээмж, үр ашгийг гурав дахин нэмэгдүүлэх боломжтой ажээ.

Үндсэндээ хог хаягдал гарахааргүй байдлаар буюу задлаад өөр зүйлд ашиглахаар үйлдвэрлэхийн тулд үйлдвэрлэлийн дизайн, хийц, загварыг бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй болно. Бараа бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх, ашиглахаа больсон зүйлсийг буцаан худалдан авах систем нэвтрүүлэх, эдэлж хэрэглэж байсан зүйлсийг дахин борлуулах худалдааг нэмэгдүүлэх, загвар хийцийг нь бага зэрэг өөрчлөөд өөр зориулалтаар ашиглах зэрэг нь циркуляр эдийн засгийн нэг хэсэг нь юм.

Манай улсын хувьд циркуляр эдийн засагт шилжихийн тулд эхлээд хог хаягдлыг ангилж, дахин боловсруулахад анхаарах хэрэгтэй байгаа юм. Өнөөдөр цахилгаан болон электрон багаж хэрэгслийг хаяхдаа ашигтай металл эд анги болон хортой элемент агуулсан эд ангийг салгахгүйгээр шууд хогийн цэгт аваачиж, газарт булсанаар байгаль орчин, газар, усыг бохирдуулж байна. Гар утас, зөөврийн хэрэгсэл, компьютерын хатуу диск нь мөнгө, зэс зэрэг үнэ хүрэх металл эд ангиас гадна хар тугалга, мөнгөн ус, кадми зэрэг хортой химийн бодисыг мөн агуулдаг. Бусад улсад ашиглагдахаа больсон, утаа тортог ихээр ялгаруулдаг хуучин машин, техникийг импортоор оруулж ирж байгааг татварын бодлогоор хааж, өөрсдөө машин үйлдвэрлэх, угсарч болох боломж байна.

Нүүрс хүчлийн хийг хязгаарлах, сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах нь шинэ эдийн засагт шилжих хоёр дахь үндсэн алхам болно. Нар салхи, усны эрчим хүчийг ашиглах явдлыг бодлогоор дэмжиж, хөрөнгө оруулалтыг чиглүүлснээр агаарын бохирдлоос салахад тустай.

Түүнчлэн бараа нийлүүлэлтийн сүлжээнд олон компаниуд хамтран ажиллаж, дахин дахин нэмүү

өртөг үйлдвэрлэж болно. Байгалийн баялгийг үр ашигтай, зүй зохистой ашиглахад нийлүүлэгчид сүлжээ болон онлайн платформ, технологи, тоон технологийг өргөнөөр ашиглана. Ингэснээр виртуал орчинд нэмүү өртгийг бий болгож, 3D принтер ашиглан хэвлэж өгөх, онлайн байдлаар харуулах, хэрэглэгчидтэй виртуал орчинд холбогдож, хамтран ашгаа нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Циркуляр эдийн засагт шилжсэнээр бизнесийн шинэ загварыг бий болгож, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэн, шинэ шинэ ажлын байр бий болгох боломжтой юм. Үүнтэй холбогдуулан бизнесийн циркуляр загвар гэсэн ойлголт гарч ирээд байна. Барааг үйлдвэрлэхээ өмнө хаягдал болсных нь дараа хэрхэн ашиглахаа давхар бодож байж үйлдвэрлэхийг бизнесийн циркуляр загвар гэж нэрлээд байгаа юм.

Үндсэндээ циркуляр эдийн засагт шилжихэд бизнесийн загвар бүхлээрээ өөрчлөгдөж ашиглахаа больсон ч гэсэн үйлдвэрлэлийн явцад бий болсон өртөг хадгалагдсаар байх юм. Ингэхээр барааны үнэнд ашиглахын өмнөх үнэ, ашиглалтын үнэ, ашигласны дараах үнэ шингэнэ гэсэн үг. Барааны эдэлгээний хугацаа уртсахаар түүнийг ашиглах хэд хэдэн хэрэглэгч бий болж, циркуляр түншүүд болон тэдний хамтын ажиллагаа циркуляр үнийн сүлжээг үүсгэнэ.

Циркуляр эдийн засаг нь дизайны хувьд дахин сэргээх, дахин боловсруулагдаж ашиглагдах систем бөгөөд бараа бүтээгдэхүүн, эд анги, материалыг дээд зэргээр ашиглаж, хэрэглээний шат тутамд нэмүү өртөг бий болгоно.

Циркуляр эдийн засаг өртгийг дахин дахин бий болгох механизмтай бөгөөд материалыг эцэст нь тултал дахин сэргээж, дахин боловсруулж, дахин дахин ашиглана. Энэ эдийн засгийн ачаар боловсруулах, засвар үйлчилгээ хийх, түрээслэх болон шинэ технологи нэвтэрч, инновацийн салбарт ажлын шинэ байрууд ихээр нэмэгдэж, хүн бүр ажилтай орлоготой байх боломжтой болно.

Монгол Улс циркуляр эдийн засагт хэрхэн шилжих талаар стратеги боловсруулах шаардлага гарч ирж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТИЙН ЖИЛҮҮДЭД ТӨВ БАНК ИНФЛЯЦИЙГ ХЭРХЭН “ЧӨДӨРЛӨХ” ВЭ?



Монголбанкнаас сэтгүүлчид дунд “ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ” сэдвийн хүрээнд зарласан “Шилдэг нийтлэл”-ийн уралдааны тэргүүн байрын бүтээлийг танилцуулж байна.

Анх 2000 оны дундуур оюутан болж байсан залуус сайн мэдэх байх. Тухайн үед сургуулийн дотуур байранд суурьшиж, сар бүр гэрээс гуйвуулах 20 мянган төгрөгөөр под хийтэл амьдарчихдаг байлаа. Хэдэн кг мах, гурил, будаа, хүнсний ногоо нөөцлөөд авчихвал сэтгэл амарч, өлсөх зовлонгүй төгссөн юм даг. Харин одоогийн оюутнууд 20 мянган төгрөгөөр юу авах бол? Үрэлгэн нэгэн 2-3, хэмнэж чадсан нь 4-5 хоног тэсч байна. Энэ бол инфляцийн хор хөнөөл юм. Хүүхдээ дээд сургуульд сургана хэмээн тав, гурван “цаас” цааш хийж, тэтгэвэрт гарсны дараа хэрэглэнэ хэмээн цалингаасаа багахан ч болов хурааж байгаа хүний мөнгөнөөс инфляци ямар ч зөвшөөрөлгүйгээр хумсалж орхидог. Тухайлбал, инфляци жилийн 15.1 хувь байвал тав хүрэхгүй жилийн дотор юмны үнэ хоёр дахин үнэтэй болно. Тийм ч учраас зарим улсын тэргүүн инфляцийг дээрэмчинтэй зүйрлэсэн нь зүгээр нэг сэтгэлийн хөөрлөөр хэлчихсэн үг биш.

Иймээс улс орны Төв банкууд инфляци буюу үнийн түвшинг тогтвортой барихад онцгойлон анхаардаг. Ялангуяа, эдийн засаг нь тогтвортой өсөхийн хэрээр

инфляцийг нам түвшинд байлгахад толгойгоо илүүтэй гашилгаж байдаг. Уг нь инфляцийг барих үйлдэл нь амархан л даа. Төв банк бодлогын хүүгээ нэмэгдүүлээд боллоо. Ингэснээр зах зээл дэх мөнгөний урсгал татарч, инфляци хүссэн хүсээгүй номхон хүлцэнгүй болоод ирнэ. Өнгөрсөн намар манай улсад дефляци үүссэнийг хэн хүнгүй мэднэ. Энэ нь өрхийн хүнсний хэрэглээнд хамгийн их жин дардаг мах, ногооны үнэ эрс хямдарснаас үүдэлтэй байв. Худалдан авалтыг нийлүүлэлт нь давснаар үнэ хямдарч, дефляци үүсэх суурийг бүрдүүлдэг. Тухайн үед тарган хонины гулуузыг 70 мянган төгрөгт багтаагаад авчихаж байлаа. Ийм байхад орой бүр тогоо дүүрэн мах чанаж зооглоод байсан ч болох биз. Тэгэхээр инфляци нам түвшинд байх нь их ашигтай байгаа биз? Бас инфляцийг бууруулах үйлдэл нь амархан. Нэг шийдвэр гаргаад боллоо. Ингэхээр төв банк инфляцийг бага түвшинд барихад анхаараад байвал болоо юм биш үү?

Харамсалтай нь тийм боломж байхгүй. Хэдийгээр инфляци бага байх нь сайхан, бууруулах үйлдэл нь амархан ч эдийн засгийн өсөлт хэмээх инфляциас

дутахгүй чухал зүйл бий.

Аливаа эдийн засагт мөнгөний урсгал нэмэгдэж байж бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, үйлдвэрлэл явагдаж, хүмүүс ажилтай болж, орлогоороо худалдан авалт хийж эдийн засгийг идэвхжүүлдэг. Үүний дүнд төр татвараа бүрдүүлж, бодлогоо хэрэгжүүлж, тэтгэвэр тавьж, нийгмийн эмзэг бүлгээ тэтгэн дэмждэг. Иймд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нь улс орны нэн тэргүүний зорилт байхаас өөр аргагүй. Ийм учраас инфляцийг тогтвортой барих, эдийн засгийн өсөлтийг хангахад Төв банкнаас маш торгон мэдрэмж, бодлого шаарддаг.

Өнгөрсөн хугацаанд Төв банк дээрхтэй холбоотой хүнд шийдвэрүүдийн өмнө олон удаа тулж ирж байв. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2011-2012 оны үед 17 хувийн өсөлт үзүүлж байлаа. Энэ нь дэлхийд гайхагдах маш сайн үзүүлэлт боловч эдийн засгийн өндөр өсөлтийг дагаад инфляци 14 хувь давсан. Мөн өнгөрсөн Засгийн газрын үед Төв банкнаас олон их наяд төгрөгийг барилгын салбар болон бусад төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулсан. Энэ нь эдийн засгийн хямралыг сааруулж, өсөлтийг тогтоон барих гэсэн бодлоготой уялдаатай боловч “ногоон”-ы ханшийг чангаруулах нэг шалтгаан болсныг хүлээн зөвшөөрөх учиртай. Мэдээж энэ тохиолдолд төгрөгийн үнэ цэнэ буурна. Импорттоос хэт хамааралтай манай улсын хувьд илүү өндөр өртөгтэйгөөр бүтээгдэхүүн худалдан авах шалтгаан болно.

“Юмны үнэ өссөн бол эргээд буурна гэж байхгүй шүү” хэмээн та хэзээ нэгэн цагт үглэж байсан биз. Инфляцийн нэг том хор уршиг нь энэ. Нэгэнт инфляци өндөр түвшинд тогтчихвол бууруулахад тун төвөгтэй болчихдог. Инфляци өндөртэй байсан улсууд ерөнхийдөө өндөртэйгөөрөө үлддэг. Индонези, Чили зэрэг цөөн улс өндөр инфляци бууруулж чадсан жишээ байдаг ч өндөр инфляцитай улсуудын инфляци ихэнхдээ улам гаарсан байдаг. Иймээс инфляцийг аль болох нам түвшинд байлгах, үүний тулд эдийн засгийг урт хугацаанд аажим аажмаар тогтвортой өсгөх шаардлагатай аж. Үүнтэй холбоотой нэг жишээ дурдвал, өндөр хөгжлөөрөө гайхуулагч Сингапурын эдийн засгийн жилийн дундаж өсөлт 8.1 хувьд тогтвортой явж иржээ. Тэд манайх шиг эдийн засгаа гэнэт 17 хувь өсгөж, хэдхэн жилийн дараа эргээд 1-2 хувь болтол унагасангүй. Харин 8.1 хувь гэсэн өсөлтийг ганхуулалгүй тогтвортой бариад яваад байжээ. Үүний дүнд тус улсын 40 жилийн дундаж инфляци ердөө 3.2 байх жишээтэй.

Үүнтэй холбоотойгоор бидний өмнө тулгарах дараагийн том сорилт тодорхойлогдоно. Тодруулбал, Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Бид Олон Улсын Валютын Сан”-гийн түүхэнд тухайн улсын ДНБ-тэй нь харьцуулахад хамгийн өндөр дүнтэй санхүүжилт авна.

Манай улсын ДНБ 10.5 тэрбум ам.доллар. Тэгвэл ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд 5.5 тэрбум ам.долларын зээл авч байна. Иймд 2019 он гээд хөтөлбөр дуусахад Монгол Улсын гадаад болон дотоодын өрийн хэмжээ өнөөгийнхөөс нэг их бууж чадахгүй. Иймд бид өрийн удирдлагын тогтвортой байдлыг хангах ямар гарц харж байна гэвэл, эдийн засгаа хурдтай томруулна. 2016 онд манай ДНБ 24 орчим их наяд төгрөг байсан бол 2020 он гэхэд 40 их наядад хүргэх шаардлага гарна. Өрийн хэмжээ буугаагүй боловч эдийн засаг 60 орчим хувьтай томорчихвол өрийн удирдлагын тогтвортой байдал бий болно. Хөгжлийн суурь бий болно гэсэн тооцоо хийсэн” хэмээсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийг богино хугацаанд хурдацтай өсгөх нь ээ. Тэгвэл үүнийг дагаад нөгөө талд инфляци өсөх эрсдэл гарч ирнэ. Иймээс ирэх жилүүдэд Төв банкнаас эдийн засгийн өсөлтийг хангахтай зэрэгцэж инфляцийг тогтвортой барих өндөр ур чадвар, торгон мэдрэмж шаардах нь гарцаагүй боллоо.

Өндөр инфляцитай улс орнууд үндсэндээ хоёр аргаар тэмцэж байна. Нэгдүгээрт, “Инфляцийг онилох” бодлого буюу Төв банкныг инфляцийн хувь хэмжээг бага түвшинд тогтвортой барьж байх цорын ганц үүрэгтэй болгож үүнийг гүйцэтгэхэд нь ямар арга хэмжээ авах шаардлагатай байна, түүнийг хийх бүрэн эрхээр хангах явдал. Өндөрсгөсөн эрхтэй нь уялдуулж хүлээх хариуцлагыг нь ч нэмэгдүүлнэ. Хоёрдугаарт, үндэсний валютаа гадаад валюттай уях эсвэл түүнээсээ бүрмөсөн татгалзаж тогтвортой валютыг өөрийн болгон хэрэглэх. Ингэснээр Засгийн газрын шахалт дарамтаар болон сайн дураараа төв банк мөнгө хэвлэн гаргах боломж нь механикаар хаагдана.

Эдгээр бодлогуудыг зарим улс дангаар, зарим нь хослуулан хэрэгжүүлж байгаа. Аль ч тохиолдолд бодлогодоо тууштай байж үүнтэйгээ зэрэгцүүлэн мөнгөний нийлүүлэлтийн хурдаа эрс багасгаж санхүүгийн сахилга батыг төсвийн бүх шатанд хэрэгжүүлж, төрийн секторынхоо нийт эдийн засагт эзлэх хэмжээг цомхотгож, хэмнэлтээс нь төрд ажиллагсдын чадвар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, түүнд нь дүйцэх нөхөн төлбөрийг олгох зайлшгүй шаардлагатай байдаг аж. Үүний үр дүнд Бразил Улс 1999-2006 онд дундаж инфляцийг жилийн 8 хувь болгож чадсан юм. Мөн Чили, Мексикт өнөөдөр инфляци мөн л буурч Төв банкнууд нь инфляцийг жилд 2-4 хувьд барих зорилго тавин ажиллаж байна. Манайд ямар бодлого, чиглэлээр явах нь төрийн шийдэх асуудал.

Эцэст нь тэмдэглэхэд, эдийн засгийн өсөлтийг хангах, инфляцийг тогтвортой барих ямар ч бодлого хэрэгжүүлсэн орхигдуулж болохгүй нэг чухал зүйл нь нефтийн хараат байдлаас салах явдал юм.

Newsmedia.mn сайтын сэтгүүлч Г.Батзориг



Даатгалын Зах Зээл

2017 оны 2-р улирлын байдлаар



Монгол Улсад


1934 он - “Улсыг Аюулаас Хамгаалах Газар” байгуулагдав

1990 он - УДЕГ-г “Монгол даатгал” ХХК болгож анхны даатгалын компанийг байгуулсан


1997 он - Даатгалын тухай анхны хуулийг 12 сард УИХ-аас батлан гаргасан

2006 он - Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулахаар Санхүүгийн Зохицуулах Хороо байгуулагдав



Эх сурвалж:
Үндэсний Статистикийн
Хороо




Нийт хураамжийн орлогын задаргаа



Үйл ажиллагааны үзүүлэлт /улирлаар/



Даатгалын зах зээлд оролцогчдын схем



ҮНЭТ МЕТАЛЛЫН СОРЬЦ ХЯНАЛТЫН ГАЗАР
Утас: 7577-8430



Сараа: - Энэ таны "Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн". Та энэ бичгээ аваад Монголбанкинд алтаа тушааж болно.



Нараа: - Таны алтыг жинлэчихлээ, та иргэний үнэмлэхээ авна уу. Удахгүй таны дансанд бид төлбөрийг шилжүүлэх болно оо.

... Таны дансанд орлого орлоо.



- Өө, Монголбанкинд тушаасан алтны мөнгө дансанд ороод ирлээ. Улсдаа алтаа тушааж эх орныхоо хөгжилд бага ч гэсэн хувь нэмрээ оруулаад явж байна даа. Алтныхаа мөнгөөр гэр орныхоо хэрэгцээтэй зүйлсийг аваад эхнэр хүүхдүүддээ очье доо.



ТАНЫ МОНГОЛБАНКИНДАА ТУШААСАН АЛТ БОЛГОН
ТАНЫ БОЛОН МОНГОЛ ОРНЫХОО ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТИЙН ТӨЛӨӨ!



МОНГОЛБАНКИНДАА
МОНГОЛ АЛТАА ТУШААЦГААЯ!



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

МОНГОЛБАНКИНДАА
МОНГОЛ АЛТАА ТУШААЦГААЯ!

МОНГОЛБАНКИНД
АЛТАА ХЭРХЭН ТУШААХ ВЭ?

- "МОНГОЛ АЛТ" АЯН -



МОНГОЛБАНК, ЭРДЭНЭСЭЙН САН:

32-96-77

www.mongolbank.mn



МОНГОЛБАНКИНДАА
МОНГОЛ АЛТАА ТУШААЦГААЯ!



Очиороо:
- Бүгдээрээ олборлосон алтаа Монголбанкинд тушаахаа. Монголбанк нь Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, иргэний үнэмлэх, битүүмжилсэн уутанд савласан алтыг хүлээн авч, төлбөрийг тухай бүр өгч байна.

Балдан:
- Олборлосон алтаа ямар замаар арилжих вэ? ... За байх! Ер нь явж, учир мэдэх хүмүүсээс асууж сураглаж, туршлага судалдаг хэрэг ээ!



Балдан:
- Монголбанкинд тушаахаар бөөн бичиг цаас бүрдүүлээд, дээр нь татвар хурааж төлдөг гэсэн биз дээ.

Очиороо:
- Үгүй дээ, Иргэний үнэмлэх, сорьцын бичигтэйгээ очиход л бол оо. Ер нь Монголбанкинд алтаа тушаах нь хамгийн найдаартай бас чирэгдэлгүй. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2.5 хувиа төлөөд л үлдсэн мөнгө дансанд чинь шууд ороод л ирнэ.



Очиороо:
- Сайн уу. Балдан, Нөгөө зарсан алтныхаа мөнгийг өнөөх чөмж залуугаасаа авч чадав уу?

Балдан:
- Чадаагүй ээ. Шороо ухаж ухаж, өчнөөн сар дарж байж, овоо хэдийг олчих санаатай урагшаа горхах гээд өгчихсэн чинь өнөөх чөмж маань хил дээр хуралгачихсан гээд ер халгаадаггүй ээ.

Очиороо:
- Иш, Балдан, олборлосон алтаа сорилтын дүнтэй нь, битүүмжилсэн уутанд савлаад Монголбанкны Эрдэнэсийн санд тушаасан нь ер нь хамгийн зөв, хялбар юм байна шүү.



АЛТ ОЛБОРЛОГЧ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН АКТУУД:

1. Эрдэнэсийн сангийн тухай хууль,
2. Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам
3. Ашигт малтмалын тухай хууль
4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам

Нэмж тодруулах зүйлээ Та Монголбанк - Эрдэнэсийн сангийн утас: **32-96-77** дугаарлуу залгаж асуугаарай.



... - Бид чинь газрын баялгийнхаа үр шимийг хүртэж байгаа улс, эргээд улсдаа татвараа төлж, байгалиа нөхөн сэргээх үүрэгтэй гэж боддог. Алтаа Монголбанкнаа тушаавал алс ирээдүйд бидний үр хүүхдүүдийн ажиллаж амьдрах, аймаг, нутгийн маань хөгжил дэвшилд л үр өгөөжөө өгнө дөө. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Хувь хүний орлогын албан татвараа төлж байвал ирээдүйд тэтгэвэрээ авчихна, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдана гээд их л хэрэгтэй болж байна шүү.

- Уг нь бидэн шиг хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлдэг хүмүүс олсон хэдээ хил, гааль дээр хураалгаж байхаар Монголбанкиндаа тушаачихвал мангасаа гадна, улсандаа эдийн засагт ч, нутаг орныхоо хөгжилд ч хувь нэмрээ оруулаад нэг ч гэсэн цэцэрлэг шинээр баригдвал зүгээр юм даа. Ерөөсөө хот орж алтаа сорьцуулна аа.





МӨНГӨН ДЭВСГЭРТІЙН НУУЦЛАЛ, ТАНИХ ТЭМДГҮҮД

20000 - ТЫН ДЭВСГЭРТІЙН НУУЦЛАЛ, ТАНИХ ТЭМДГҮҮД

Дэвсгэртийн нүүрэн талын зүүн болон доод ирмэгийн дагуу MONGOLBANK гэсэн жижиг бичилттэй.

МОНГОЛ УЛС гэсэн үгийг эвхэмэл монгол үсгээр бичсэн хэсэг, дэвсгэртийн гол хэсэгт байрлах **соёмбо, хагас дугуй хээ, 20000** гэсэн тоо, монгол бичгээр **монгол банк** хорин мянган төгрөг гэж бичсэн хэсгүүдийг гарт мэдрэгдэх товгор хэвлэлтийн технологиор хэвлэсэн.

Тусгай тунгалаг материалаар хийсэн зуйван дугуй хэлбэрийн цонх байгаа бөгөөд бараан суурин дээр цонх дотор **ᠡ** гэсэн дүрс тодорч, цайвар суурин дээр **ᠠ᠋᠋ᠠ᠋᠋** гэсэн тоо тодорч харагдана.

Дэвсгэртийн хоёр талд байрлах Чингис Хааны гэрэгэгийн дээд хэсгийн дугуй дүрсүүд зөрүүгүй **давхцана**.



Гэрлийн эсрэг барьж харахад **Чингис хааны** хөрөг, **ᠡ** гэсэн дүрс усан хээгээр тодорч харагдана.

4 морьтон баатрын дүрс болон дэвсгэр өнгө 4 хэсэгт хуваагдаж үзэгдэнэ.



3 миллиметрийн өргөнтэй тасалдаж харагдах металл утсыг гэрлийн дагуу жишүү барьж харахад дотор нь **Соёмбо тэмдэг** мөн **20000** гэж бичигдсэн нь харагдах бөгөөд олон өнгөөр солонгорч үзэгдэнэ. Гэрлийн эсрэг барьж харахад урт хар тууз мэт болж, дотор нь **MONGOLBANK** гэсэн бичиг уншигдана.

Давхацсан босоо өлзий хээний дунд Төрийн цагаан тугийг холограмаар хэвлэж доор нь **20000** гэсэн тоог латин, монгол бичгээр хэвлэсэн.

2006 онд хэвлэгдсэн 20000-тын дэвсгэртийн онцлог:

- Мөнгөн дэвсгэртийн нүүрэн талын голд байрлах Соёмбо, арын хээг холограмаар хэвлэсэн.
- Тусгай тунгалаг материалаар хийсэн цонх, Төрийн цагаан туг дүрсэлсэн холограм байхгүй.

5000, 10000 - ТЫН ДЭВСГЭРТІЙН НУУЦЛАЛ, ТАНИХ ТЭМДГҮҮД

Дэвсгэртийн нүүрэн талын зүүн болон доод ирмэгийн дагуу MONGOLBANK гэсэн жижиг бичилттэй.

МОНГОЛ УЛС гэсэн үгийг эвхэмэл монгол үсгээр бичсэн хэсэг, **5000, 10000** гэсэн тоо монгол бичгээр **монгол банк** таван мянган төгрөг, **монгол банк** арван мянган төгрөг гэж бичсэн хэсгүүдийг гарт мэдрэгдэх товгор хэвлэлтийн технологиор хэвлэсэн.

Дэвсгэртийг гэрлийн эсрэг барьж харахад 2 миллиметрийн өргөнтэй **металл утас** харагдана.

Дэвсгэртийн хоёр талд байрлах Чингис хааны гэрэгэгийн дээд хэсгийн дугуй дүрсүүд зөрүүгүй **давхцана**.



Гэрлийн эсрэг барьж харахад **Чингис хааны** хөрөг, **ᠡ** гэсэн дүрс усан хээгээр тодорч харагдана.

Дэвсгэртийн нүүрэн талын баруун доод буланд **морьтон баатрын дүрс** харагдана.



Мөнгөн дэвсгэртийн нүүрэн талын голд байрлах Соёмбо нь 10000-тын дэвсгэртийн хувьд холограмаар, 5000-тын дэвсгэртийн хувьд мөнгөлөг металл дардасаар хэвлэгдсэн.

Мөнгөн дэвсгэртийн хоёр талын суурь нь хувилагчийн эсрэг хийцтэй.

1994 онд хэвлэгдсэн 5000, 1995 онд хэвлэгдсэн 10000-тын дэвсгэртийн онцлог:

- Мөнгөн дэвсгэртийн нүүрэн талын голд байрлах соёмбо нь энгийн хэвлэлтээр хэвлэгдсэн.
- Гэрлийн эсрэг барьж харахад Чингис хааны хөрөг усан хээгээр тодорч харагдах бөгөөд **ᠡ** гэсэн дүрс байхгүй.



МОНГОЛБАНК
Хаяг: Монгол улс, Улаанбаатар-46, Бага тойруу-3, 15160
Факс: 976-11-311471